



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP



JICA  
Japan International  
Cooperation Agency



ADB ASIAN  
DEVELOPMENT  
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

# СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

МОНГОЛ ХЭЛ

УЛААНБААТАР 2021





БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН  
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ  
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

# ЗӨВЛӨМЖ

МОНГОЛ ХЭЛ

*АНХНЫ ХЭВЛЭЛ*

УЛААНБААТАР 2021



## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

---

Суралцагчийн үнэлгээ..... 2

## СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

---

Нэг. Монгол хэлний суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн онцлог ..... 5

Хоёр. Шалгуурт суурилсан үнэлгээ ..... 12

2.1. Нэгж хичээл ба үнэлгээний нэгж ..... 12

2.2. Суралцахуйн зорилт ба суралцахуйн үр дүн ..... 14

2.3. Үнэлгээний шалгуур ба гүйцэтгэлийн түвшин ..... 17

Гурав. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар ..... 23

3.1. Үнэлгээний даалгавар боловсруулах нь ..... 23

3.2. Нэгж хичээлийн үнэлгээний даалгаврын жишээ: ..... 23

Дөрөв. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал..... 33

## СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго<sup>1</sup>/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх<sup>2</sup>/, үнэлж дүгнэх<sup>3</sup> зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ **“шалгуур”**-г суурилсан байна.

### ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд **“үнэлгээ”**-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

<sup>1</sup> Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

<sup>2</sup> Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

<sup>3</sup> Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад<sup>4</sup> нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

## ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



<sup>4</sup>Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.



<sup>4</sup>Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.



## Нэг. Монгол хэлний суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн онцлог

Бага, суурь, бүрэн дунд боловсролын монгол хэл, уран зохиол, үндэсний бичгийн сургалтын хөтөлбөрт бага ангид 153, дунд ангид 157, бүрэн дунд боловсролын заавал судлах 106, нийт 416 суралцахуйн зорилт тодорхойлсон байна. Эдгээрээс 23 нь 6-р ангийн монгол хэлний сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилт байна.

Агуулгын ай	Хичээлийн нэр	Бага боловсрол						Суурь боловсрол					БДБ-Заавал судлах					Сонгон судлах			
		I	II	III	IV	V	Нийт	VI	VII	VIII	IX	Нийт	X	XI	XII	Нийт	Нийт дүн	X	XI	XII	Нийт
Унших	Монгол хэл	13	8	9	10	11	51	8	5	7	5	25	7	7	4	18	94	4	4	3	12
	Уран зохиол							7	7	7	7	28	7	7	7	21	49	3	4	6	13
	Үндэсний бичиг						0	2	3	3	3	11	4	4	4	12	23	4	2	3	9
Хэл зүй, онол	Монгол хэл	7	4	4	4	4	23	4	3	3	1	11	4	5	3	12	46	4	4	2	10
	Уран зохиол											0				0					
	Үндэсний бичиг						0	1	3	3	1	8	5	3	0	8	16				
Бичих	Монгол хэл	12	11	11	12	12	58	9	5	7	8	29	4	5	3	12	99	3	4	5	12
	Уран зохиол							3	3	3	3	12	2	2	2	6	18	2	2	2	6
	Үндэсний бичиг							5	5	4	3	17	3	3	2	8	25	8	2	2	12
Сонсох-ярих	Монгол хэл	5	4	4	4	4	21	2	2	2	2	8	2	1	2	5	34	2	1	1	1
	Уран зохиол							2	2	2	2	8	1	1	2	4	12	1	1	1	
	Үндэсний бичиг											0				0					
		37	27	28	30	31	153	43	38	41	35	157	39	38	29	106	416				74

Монгол хэлний суурь боловсролын сургалтын хөтөлбөр нь дараах онцлогтой: Үүнд:

1. Эхэд суурилсан хэлний зүйн мэдлэг эзэмшүүлж, түүнийгээ хэрэглэх чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн агуулгатай. Өөрөөр хэлбэл монгол хэлний сургалтын гол хэрэглэгдэхүүн бол уран зохиолын болон уран зохиолын бус эхүүд байх болно гэсэн үг. Суурь боловсролын сургалтын хөтөлбөрт анги бүрд тодорхой хэв маягаар бичгдсэн эхийг судлахаар, тухайлбал 6-р ангид хүүрнэсэн, 7-р ангид дүрсэлсэн, 8-р ангид тайлбарласан, 9-р ангид эргэцүүлсэн хэв маягт хамаарах эхийг үндсэн хэрэглэгдэхүүн болгохоор тусгасан. Эх нь монгол хэлний сургалтын амин сүнс бөгөөд аль ангид ямар ямар эх сонгон ашиглахыг суралцахуйн удирдамж, сурах бичигт санал болгон оруулсан байдаг.
2. Унших, бичих, хэлний зүйн агуулга хоорондоо уялдаа холбоотой. Тухайлбал, тухайн ангид уншсан эхийг задлан шинжлэх замаар түүний бүтэц, агуулгын уялдаа холбоог олж сурахын зэрэгцээ хэлний зүйн ямар онцлог хэрэглээ байгааг судлан тодорхойлно. Улмаар уншсан эхийн бүтцийн онцлогт тохирсон эх зохион бичиж сурах дадлага хийнэ.

3. Сургалтын хөтөлбөрийн зарим суралцахуйн зорилт бүхэллэг, нэгж хичээл бүрээр дахин дахин хэрэгжихээр томъёологдсон. Тухайлбал, унших /6.1а, 6.1б, 7.1а, 7.1б, 8.1а, 9.1б/ болон бичих айн /6.2а, 6.2б, 7.2а, 7.2б, 8.2а, 8.2б, 8.2в, 9.2а, 9.2б, 9.2в дэх сургалтын зорилтууд жилийн турш нэгж хичээл бүрд давтагдан хэрэгжих болно. Сургалтын хөтөлбөрийн зарим суралцахуйн зорилт нь жилийн турш судлахаар харьцангуй ерөнхий тул нэгж хичээл бүрээр нарийвчлан томъёолж хэрэгжүүлдэг.
4. Сурах бичгийн зохиогчид анги бүрийн хөтөлбөрийн агуулгыг нэгж хичээлд хуваарилж, сурах бичгээ бүтэцчилдэг. Багш нар ч үүнийг үндэслэн сургалтын төлөвлөлтөө хийж хэвшсэн байна. Сурагчдад ч энэ нь ойлгомжтой болдог.

Сурах бичгийн нэгж хичээлийн агуулга нь унших, хэлний зүй, бичих, гэсэн хэсгээс бүрддэг. Нэгж хичээл бүрийн төгсгөлд үнэлгээ хийхэд бидний боловсруулсан үнэлгээний шалгуурыг баримтлан даалгавар боловсруулж, сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварын түвшнийг тогтооно.

**СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР БА СУРАЛЦАХУЙН ЗОРИЛТ  
СУУРЬ БОЛОВСРОЛ**

Сургалтын хөтөлбөрийн үнэлгээний шалгуур	ҮI анги	ҮII анги	ҮIII анги	ҮIII анги
<b>УНШИХ ЧАДВАР</b>				
	Хүүрнэсэн эх /Захидал, намтар, өдрийн тэмдэглэл, мэдээ, өгүүллэг, үлгэр/	Дүрсэлсэн эх /Аян замын тэмдэглэл, найруулал, товч танилцуулга, илтгэх хуудас/	Тайлбарласан эх /Шинжлэх ухаан танин мэдэхүй, байгаль хамгаалах сэдэт эхүүд/	Эргэцүүлсэн эх /Уншигчийн захидал, шүүмж/
А.1 Хүүрнэсэн эхийн агуулга, гол санааг ойлгосноо харуулах	6.1в. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгүүдийн уялдаа холбоог тогтоож гол санааг нь тодорхойлох	7.1в. Эхийн сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох	8.1б ... тайлбарласан эхийн сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох	9.1.б Учир шалтгааны тайлбарласан, таамаглал дэвшүүлэн тайлбарласан эхийн сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох
А.2 Эхийн шууд ба далд утга, өнгө аясыг ойлгосноо харуулах	6.1д. Уншсан эх доторх харилцан ярианы үүргийг тодорхойлох	7.1г. Эхээс сонин содон үг хэллэг, уран дүрслэл /адилтгал, ихэсгэл, багасгал, амьдчилал/, хэлцийг олж таних, чухал хэсэг		

<p>A3. Эхийн агуулгын бүтцийн уялдаа холбоо, орон, цаг хугацаа, орны цагийн дараалал, учир шалтгаан, чухал чухал бус, уялдаа холбоог задлан шинжлэх, дүгнэх</p>	<p>6.1а, 6.1б ... эхийн бүтэц, орон цагийн дараалал, учир шалтгааны уялдаа холбоо, бүтцийг задлан шинжилж эхийн үндсэн шинжийг ялган таних 6.1г. Уншсан эхээс орон ба цагийн дүрслэлээр үйл явдлын орчныг тодорхойлох 6.1ж. Уншсан эхээс чухал хэсгийг олж, бичигчийн санааг тайлбарлах</p>	<p>7.1а, 7.1б . ...хүн, юм үзэгдлийн газаад, дотоод шинж, үйлийн хувирал өөрчлөлтийг дүрсэлсэн болон тоочсон эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилж эхийн үндсэн шинжийг ялган таних 7.1д. Эхээс чухал хэсгийг олж, үндэслэлийг нь тайлбарлах</p>	<p>8.1а.Тоочин тайлбарласан, учир шалтгааны тайлбарласан эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилж эхийн үндсэн шинжийг ялган таних</p>	<p>9.1а. ... тайлбарласан эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилж үндсэн шинжийг ялган таних 9.1г. Эхийн агуулгыг баримт- үзэл бодол, шалтгаан -үр дагавар, таамаглал, баталгаа нотолгооны холбоо хамаарлыг ялган тодруулах</p>
<p>A4. Эхэд хэрэглэсэн баримт, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлыг шинжлэх, үнэлж дүгнэх</p>	<p>6.1е. Уншсан эхээс зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлсэн хэсгийг ялгаж, зохиогчийн сэтгэлийн өнгө аясыг тайлбарлах</p>		<p>8.1в. Уншсан эхээс зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлсэн хэсгийг ялгаж, учрыг тайлбарлах 8.1ж. Уншсан эхэд зохиогчийн ашигласан баримт, мэдээллийг ялгаж, дүгнэлт гаргах</p>	<p>9.1в. 8.Зохиогчийн үзэл бодол, мэдрэмж сэтгэгдэл, бичлэгийн өнгө аясыг дэвшүүлсэн асуудал, дүгнэлт өгүүлбэрийн уялдаа холбоог баймж нэгжүүдээр тодорхойлж тайлбарлах</p>
<p>A5. Эхийн хэл найруулга, арга хэрэглүүр, үг хэллэгийн үр нөлөө, зорилгыг тайлбарлах</p>		<p>8.1г. Албан бичгийн эхийн бүтэц, үгийн санг задлан шинжилж, найруулгын онцлогийг тодорхойлох</p>		<p>9.1е. Өөр өөр цаг үед бичигдсэн ижил сэдэвтэй эхийн үгийн санг харьцуулах</p>
<b>БИЧИХ ЧАДВАР</b>				
<p>B1. Сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодол, төсөөллөө үр дүнтэй илэрхийлэх</p>	<p>6.2а, 6.2б. ....-г орон цагийн дарааллаар өрнүүлэн бичих</p>	<p>7.2а ...гадаад дотоод шинжийг тоочин дүрсэлж бичих</p>	<p>8.2а. ...учир шалтгааныг тайлбарлаж бичих 8.2в. Албан бичгийн тогтсон бүтэц, дагуу учир шалтгааны уялдаа холбоотой бичих</p>	<p>9.2б. ... асуудал дэвшүүлэн шалтгаан үр дагаврын холбоог гаргаж бичих</p>

Б2. Уншигч, сонсогчдод сонирхол төрүүлэхээр баримт мэдээлэл, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо дараалалд оруулж илэрхийлэх	6.2в. Өгсөн сэдэв, гол санаанд тохируулан үйл явдлыг сонгож бичих 6.2г. Эхэд өөрийн санаа бодол, харилцан яриа оруулан дэлгэрүүлж бичих 6.2д. Хэлц ашиглан мэдрэмж, сэтгэгдлээ дүрслэн бичих	7.2б. хэлц, уран дүрслэл, дүрслэх ба дуурайх үг ашиглах үйлийн хувирал өөрчлөлтийг дүрсэлж бичих	8.2б. Хэлц, уран дүрслэл ашиглан мэтрэмж, сэтгэгдэл, үзэл бодлоо тусган найруулж бичих 8.2в. Жишээ баримт ашиглан дүрслэн тайлбарлаж бичих 8.2г. Угсруулан холбох үг нөхцөл ашиглан учир шалтгааны тайлбарлаж биих	9.2в. Асуудал дэвшүүлэн тайлбар, үзэл бодол, дүгнэлтийг уялдаа холбоотой илэрхийлж бичих
Б3. Санаагаа зорилго, нөхцөл байдалд тохируулан эш үндэстэй тодорхой илэрхийлэх	6.2е. Товч мэдээллийг баримтаар дэлгэрүүлэх 6.2ж. Үйл явдлыг хэн, хаана, хэзээ, юуг, яагаад, хэрхэн, яав гэсэн асуултаар дэлгэрүүлэх	7.2б. Тооны нэр, баримт нотолгоо, жишээ ашиглан тоочин бичих /загварт/	8.2а. Жишээ баримтаар баталж, уялдаа холбоотой тайлбарлаж бичих	9.2а. Асуудал дэвшүүлэн таамагдаж бичихдээ баталж нотолж, үгүйсгэж бичих 9.2е. Баримтад үндэслэн тайлбарлан бичих
<b>ЯРИХ-СОНСОХ ЧАДВАР</b>				
Б4. Харилцан ярианы үед бусдыг анхааралтай сонсож хариулт өгөх, тодруулан асуух	6.3а. ... ярилцахдаа гол асуудлыг ойлгон, асууж тодруулах 6.3б. Санаа бодлоо бусдынхтай холбон харилцан ярих	7.3а. ... тулгамдсан асуудлыг судалж, санаа бодлоо илэрхийлэн 7.3б. Хэлэлцүүлэгт баталж нотолж, дэмжиж, үгүйсгэж ярих	8.3а. ..сонсогчоо мэдэрч, баримт мэдээлэл ашиглан илтгэх 8.3б.... асуудал дэтшүүлэн баталж, нотлон тайлбарлаж ярих	9.3а. ... баримтад үндэслэн баталж, нотолж, үгүйсгэн үзэл бодлоо илэрхийлэх
<b>ҮГИЙН САН, ХЭЛ ЗҮЙ</b>				
Үг зүй, өгүүлбэр зүй, үгийн сангийн мэдлэг ойлголт, нэр томьёо	6.1и. Жинхэнэ нэр, тийн ялгал, хамаатуулах нөхцөл, олон тооны дагавар 6.1к. Үйл үг, үйлийн төгсгөх ба холбох нөхцөл 6.1л. Энгийн өгүүлбэр, гол гишүүд ба цөм өгүүлбэр	7.1е. Тэмдэг нэр, тооны нэр, дуурайх үг 7.1ж. Хэлэх аялга, зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл 7.1з. Эсрэг ба ойролцоо утгатай зэрэгцсэн үг	8.1к. Угсарсан нийлмэл үг 8.1з. Шалтгааны утгатай угсарсан нийлмэл өгүүлбэр 8.1и. Нутгийн аялгууны үг, гадаад үг хэллэг	9.1д. -Баталсан, таамагласан, үгүйсгэсэн утгат баймж нэгж -Угсруулан ба зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл - Орон цаг, шалтгааны утгат угсарсан нийлмэл үг, бүтээвэр
<b>ЭХ ХЭЛЭЭ СОНИРХОН СУДЛАХ ХҮСЭЛ ЭРМЭЛЗЭЛ, БУСДЫН ХЭЛ, СОЁЛЫГ ХҮНДЭТГЭХ ХАНДЛАГА</b>				
Монгол хэл бичиг, үндэсний соёл, ахуй, ёс заншлыг сонирон судлах				
Хэл соёлын ялгаатай байдлыг ойлгох, хүндэтгэх, хамтран ажиллах				

## БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

Сургалтын хөтөлбөрийн үнэлгээний шалгуур	X анги	XI анги	XII анги
<b>Б. УНШИХ ЧАДВАР</b>			
Б1. Төрөл бүрийн найруулгын эхийг уншаад ойлгох, задлан шинжлэх	10.1а. Тайлбарласан эсээ, хөрөг найрууллын сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэр, цогцолбороор тодорхойлох	11.1а. Эргэцүүлсэн эсээ, аян замын тэмдэглэл, шинжлэх ухааны хялбаршуулсан эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог тайлбарлаж, сэдэв, гол санааг тодорхойлох	12.1а. Уран нийтлэлийн бүтэц, гол санааг цогцолбор, түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох
	10.1б. Тайлбарласан эсээ, хөрөг найруулал, ажлын удирдамж, тайлангийн бүтэц, агуулгын уялдаа холбоо, учир зүйн дарааллыг цогцолбор, догол мөрөөр тайлбарлах		12.1б. Ятгасан эсээний бүтэц, гол санааг цогцолбор, түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох
Б4. Зохиогчийн үзэл бодол, дүгнэлт, баталгаа нотолгоонд дүн шинжилгээ хийж, үзэл бодолтойгоо харьцуулах	10.1в. Тайлбарласан эсээний зохиогчийн ашигласан баримт мэдээлэлд дүн шинжилгээ хийх	11.1б. Зохиогчийн дүгнэлт, баталгаа нотолгоог үзэл бодолтойгоо харьцуулж, тайлбарлах	12.1в. Ятгасан эсээний агуулгыг зохиогчийн үзэл бодол, сэтгэгдэл, мэдрэмж, үнэлэлт дүгнэлт, баримтаар задлах
	10.1г. Хөрөг найруулал, тайлбарласан эсээнд зохиолгчийн үг сонгосон (уран дүрслэл, хэлц) сонгосон шалтгааныг тайлбарлах	11.1в. Уран дүрслэл, хэлц, нэр томьёо, мэргэжлийн үг хэллэгийг хэрэглэсэн зорилгыг тодруулж, утга, үүргийг тайлбарлах	12.1г. Ятгасан эсээний үгийн сан, бүтэц, зохиомж, жишээ баримт, уншигчид нөлөөлөх дүрслэл, зохиогчийн ёс зүйн хандлагыг жишээ баримтаар тайлбарлах, дүгнэх
	10.1д. Ажлын удирдамж, тайланд албаны үг хэллэг хэрэглэсэн зорилгыг тайлбарлах		
Б2. Эхэд хэлний нэгжүүдийн үүрэг, хэрэглээг үнэлж цэгнэх	10.1е. Тайлбарласан эсээнд хэрэглэсэн харьцуулсан утгатай бүтээвэр, холбох (зэрэгцүүлэх, угсруулах) үгийг олж, шалтгааныг тайлбарлах	11.1г. Орон, цаг, зорилго, шалтгааны утгыг эхийн жишээгээр харьцуулан тайлбарлах	
	10.1ж. Албан бичгийн эхийн зэрэгцүүлэн тоочсон өгүүлбэр, цэг тэмдгийн хэрэглээг тодорхойлж, үүргийг тайлбарлах		

<b>В. БИЧИХ ЧАДВАР</b>			
В2. Үр дүнтэй, бүтээлч, тодорхой, оновчтой бичсэн байдал	10.2.а. Олон ургальч үзэл бодлыг харьцуулж асуудал дэвшүүлэн тайлбарлан бичих	11.2.а. Тодорхой асуудлыг сэтгэгдэл, үзэл бодолтойгоо холбон олон талаас нь эргэцүүлэн бичих	12.2.а. Асуудал дэвшүүлэн бичихдээ баримт нотолгоо, уншигчид нөлөөлөх дүрслэл, эшлэл, зүүлт ашиглан байр сууриа илэрхийлэн ятган итгүүлж бичих
В1. Өөр өөр уншигч, зорилго, нөхцөл байдалд тохирсон бүтэц, хэв маягийг сонгосон байдал /бичгээр/	10.2б. Загварт найруулгын бүтэц, онцлог, агуулгын уялдаа холбоог гарган тоочин бичих	11.2б. Үйл явдлыг хүүрнэн бичихдээ орон цаг, нөхцөл байдлыг дүрслэн мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэх	12.2б. Уншигч, зорилго, нөхцөл байдалдаа тохирсон бүтэц, хэв маягийг сонгон бичих
В3. Үзэл бодол, мэдрэмж, сэтгэгдэл, үнэлэлт дүгнэлтийг үндэслэлтэй илэрхийлсэн байдал /бичгээр/	10.2в. Мэдрэмж, сэтгэгдэл, үнэлэмжээ баримтад тулгуурлан дүрслэн бичих	11.2в. Эшлэл, ном зүй, зүүлт, тайлбар, тулгуур бичиглэл, бүдүүвч, загвар зэргийг ашиглан бичих	
В4. Зөв бичих дүрэм, найруулгын шаардлагад нийцүүлэн бичих	10.2г. Эхийг хурааж, дэлгэрүүлж найруулан бичих	11.2г. Эхийг хурааж, дэлгэрүүлж найруулан бичих	12.2в. Эхийг хурааж, дэлгэрүүлж Найруулан бичих
		11.2д. Холбох хэрэглүүрээс сонгож, нийлмэл өгүүлбэрийг хувирган найруулах бичих	
<b>СОНСОХ-ЯРИХ ЧАДВАР</b>			
В1. Өөр өөр уншигч, зорилго, нөхцөл байдалд тохирсон бүтэц, хэв маягийг сонгосон байдал /амаар/	10.3.а. Тодорхой асуудлаар зорилго, нөхцөл байдал, харилцагчийн онцлогт тохируулан ярих	11.3.а. Тодорхой цаг хугацаа, орон зайд болсон хэрэг явдлын талаар төрсөн сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэх	12.3.а. Үзэл бодол, байр сууриа илэрхийлэн илтгэж ярихдаа жишээ баримт, эшлэл ашиглах
В3. Үзэл бодол, мэдрэмж, сэтгэгдэл, үнэлэлт дүгнэлтийг үндэслэлтэй илэрхийлсэн байдал /амаар/	10.3б. Үзэл бодол, сэтгэгдэл, мэдрэмжээ жишээ баримт, эшлэл, уран дүрслэл, хэлц зэргийг ашиглан илэрхийлэх		12.2б. Үндэслэлтэй ярих, бусдын үзэл бодлыг анхааралтай сонсож, дүгнэлт хийх

<b>А. ҮГИЙН САН, ХЭЛ ЗҮЙ</b>			
<p>A1. Хэлний баримт, зүй тогтол, онол, дүрэм, зарчим, тодорхойлолт, өөрчлөлт</p> <p>A2. Хэл шинжлэлийн онолын ойлголт, нар томьёо</p>	10.4а. Өгүүлбэрийн гишүүдийн хэлбэржилт, утга, байр, эхийн найруулгад гүйцэтгэх үүргийг тодорхойлох	11.4а. Холбох хэрэглүүрийн утга, үүргийг тодорхойлж, нийлмэл өгүүлбэрт сонгон найруулах	12.4а. Нийлмэл өгүүлбэр дэх “гэ”-т өгүүлбэрийг таних, тайлбарлах
	10.4б. Зэрэгцүүлэх, угсруулан холбох бүтээвэр, үгийн утгыг ялган таних, тайлбарлах	11.4б. Орон цаг, зорилго, шалтгааны утгатай бүтээвэр, холбох үг, өгүүлбэрийн утгыг тодорхойлж, сонгон хэрэглэх	12.4б. Өгүүлбэрийн гишүүд, гишүүн өгүүлбэр, “гэ”-т өгүүлбэр, хэлц үг зэргээр дэлгэрүүлэн найруулж бичих
	10.4в. Ойлолцоо, эсрэг утгатай бүтээвэр, үг, өгүүлбэрийнх утгыг ойлгох	11.4в. Өвөрмөц, хэвшмэл хэлцийг тухайн найруулгад сонгон хэрэглэх	12.4в. Хэлц өгүүлбэрийн гол болон үүдэл санааг тайлбарлах
	10.4г. Бичгийн найруулга зэргийг ялгах	11.4д. Нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээг таньж, эхэд гүйцэтгэх үүргийг тайлбарлах	
		11.4г. Төрөл бүрийн толь бичгийг зориулалтаар нь хэрэглэх	
<b>Г. ХАРИЛЦАА ХАНДЛАГА</b>			
Г1. Эх хэл, утга соёлын үнэт зүйлсийг эзэмших, хамгаалах, хөгжүүлэх, өвлүүлэх			
Г2. Үндэсний болон бусдын соёл, оюуны үнэт зүйлсэд хүндэтгэлтэй хандах			
Г3. Хэл соёлын ялгаатай байдлыг ойлгох, хүндэтгэх, хамтран ажиллах			

Унших, бичих, ярих-сонсох нь хэлний суурь чадвар бөгөөд нэг удаагийн үйлдлээр сайн эзэмших боломжгүй тул эдгээр чадварыг нэгж хичээл бүрээр давтан хийж байж дадал болж хөгждөг. Ийм учраас сургалтын хөтөлбөрт байгаа унших, бичихтэй холбоотой суралцахуйн зорилтыг нэгж хичээл бүрээр хэрэгжүүлэх шаардлагтай.

## Хоёр. Шалгуурт суурилсан үнэлгээ

### 2.1. НЭГЖ ХИЧЭЭЛ БА ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ


Үнэлгээний нэгжийг нэгж хичээлтэй ижил гэж ойлгож болохгүй. Үнэлгээний нэгж нь тухайн агуулгын хувьд сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг илрүүлэн дүгнэх шалгуурын нэгтгэл бол нэгж хичээл нь сургалтын хөтөлбөрийн агуулгыг томсгосон дидактик нэгжид хуваасан шийдэл бүхий агуулгын хуваарилалт юм.

#### Нэгж хичээл

ЕБС-ийн сургалтын төлөвлөгөөнд 6 дугаар ангид монгол хэлний хичээлийг долоо хоногт 3 цаг, жилд 99 цаг, харин 11-р ангид монгол хэлний хичээлийг долоо хоногт 1 цаг, жилд 34 цаг заахаар тусгажээ.<sup>1</sup>

6 дугаар ангийн сурах бичигт сургалтын хөтөлбөрийн агуулгыг 9 нэгж хичээл байхаар дидактик нэгжид хувааж, бүтэцчилсэн бөгөөд нэг нэгж хичээлд 10-11 цаг ногдож байгаа. Харин 11 дүгээр ангийн сурах бичигт сургалтын хөтөлбөрийн агуулгыг 4 нэгж хичээл байхаар бүтэцчилсэн байна. Нэг нэгж хичээлд 6-9 цаг ногдож байгаа.

Монгол хэлний хичээлийн хувьд нэг нэгж хичээл нь сургалтын хөтөлбөрийн агуулгын унших, хэлний зүй, бичих, сонсох-ярих бүрэлдэхүүн хэсэг тус бүрд хамаарах суралцахуйн зорилтыг нэгж хичээлээр хэрэгжүүлдэг онцлогтой. Ийм учраас монгол хэлний сургалтын хөтөлбөрийн агуулга нь дараалж цувсан бус, харин зэрэгцсэн бүтэцтэй байдагтай холбоотой. Гэтэл зарим хичээлийн хөтөлбөрийн агуулга нь бүлэг сэдвээр бүтэцчилэгдсэн байдаг. Иймд нэгж хичээл бүрийн дараа сурагчдын унших, бичих, хэлний зүйн агуулгын хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадварыг цогцоор нь үнэлнэ.




<sup>1</sup> Боловсрол, шинжлэх ухааны сайдын ...-р тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөө




6-р ангийн монгол хэлний сурах бичгийн бүтэц:

- I бүлэг. Харилцан яриа
- II бүлэг. Үйл явдлын уялдаа холбоо
- III бүлэг. Эхийн сэдэв, гол санаа
- IV бүлэг. Үйл явдлын орчин
- V бүлэг. Дүрүүдийн харилцан яриа
- VI бүлэг. Үйл явдлын цагийн дараалал
- VII бүлэг. Бичигчийн сэтгэлийн өнгө аяс
- VIII бүлэг. Бичигчийн санаа
- IX бүлэг. Үйл явдлын мэдээ



11-р ангийн монгол хэлний сурах бичгийн бүтэц:

- I бүлэг. Үйл явдлын орон цаг, нөхцөл байдлыг дүрслэн, мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэх
- II бүлэг. Баримт, нотолгоо, дүгнэлтийн уялдаа холбоог тодорхойлох
- III бүлэг. Асуудлыг сэтгэгдэл, үзэл бодолтойгоо холбон олон талаас нь эргэцүүлэх
- IV бүлэг. Толь бичиг, түүний хэрэглээ



**Үнэлгээний нэгж**

Монгол хэлний хичээлийн үнэлгээний шалгуурыг сургалтын хөтөлбөрийн агуулгын бүрэлдэхүүн хэсгийг баримжаалан 6-р ангид 5 нэгж, 11-р анги 4 нэгж байхаар тодорхойлсон. Тухайлбал, 6-р ангид “Унших”, “Ярих-сонсох”, “Хэл зүй” агуулгыг тус бүр үнэлгээний нэг нэгж болгосон бол “Бичих” агуулгыг зохиож бичих ба дэлгэрүүлж бичих гэж үнэлгээний хоёр нэгж болгосон.

**6-р анги**

Агуулгын ай	№	Үнэлгээний нэгж	Холбогдох суралцахуйн зорилтын код
Унших	1	Уншсан эхийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх	6.1а, 6.1б, 6.1в, 6.1г, 6.1д, 6.1е, 6.1ж, 6.1з
Бичих	2	Хүүрнэсэн эх зохиож бичих	6.2а, 6.2б, 6.2в, 6.2д, 6.2е, 6.2ж
	3	Хүүрнэсэн эхийг дэлгэрүүлэх	6.2г
Сонсох-ярих	4	Харилцан ярих	6.3а, 6.3б
Үгийн сан, хэл зүй	5	Хэлний зүйн шинж, хэрэглээ	6.1и, 6.1к, 6.1л, 6.1м

Агуулгын ай	№	Үнэлгээний нэгж	Холбогдох суралцахуйн зорилтын код
Унших	1	Уншсан эхийг уншиж ойлгох	11.1а, 11.1б, 11.1в, 11.1г
Бичих	2	Эх зохион бичих	11.2а, 11.2б, 11.2в, 11.2г
Сонсох- ярих	3	Ярих	11,3а
Хэл зүйн хэрэглээ	4	Харилцан ярих	11.4а, 11.4б, 11.4в, 11.4г, 11.4д, 11.2д

Ийнхүү үнэлгээний нэгжийг тогтооходоо дараах зарчмыг баримталсан. Үүнд:

1. Сургалтын хөтөлбөрийн агуулгын айн суралцахуйн зорилтуудыг хооронд нь холихгүй тус тусад нь нэгж болгох, тухайлбал, унших агуулгыг бичих агуулгатай, эсвэл хэлний зүйн агуулгыг унших, бичихтэй холихгүй байхыг зорьсон.
2. Унших, бичих суурь чадвар нь нэг удаагийн, эсвэл нэг нэгж хичээлээр эзэмшдэг чадвар биш. Ийм учраас дахин дахин давтаж байж эзэмшдэг суурь чадварыг үнэлэх нэгжийг нэг болгож нэгтгэсэн бол дахин давтах шаардлагагүй агуулгыг тус тусад нь үнэлгээний нэгж болгосон.

Эндээс үнэлгээний нэгж нь нэгж хичээлтэй тохирохгүй байгааг харж болно. Иймд үнэлгээний “Уншсан эхийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх”, “Хүүрнэсэн эх зохиож бичих” нэгжийн шалгуурыг бүх нэгж хичээлд давтан ашиглана. Харин “Жинхэнэ нэр, үйл үг, орон цагийн нэрийн хэл зүйн шинж, хэрэглээ” үнэлгээний нэгжийн шалгуур тус бүрийг, “Үйл явдлын уялдаа холбоо”, “Эхийн сэдэв, гол санаа, 4. Үйл явдлын орчин” нэгж хичээлийг үнэлэхдээ бүх нэгж хичээлд ижилхэн шууд хэрэглэх боломжгүй. Өөрөөр хэлбэл тухайн нэгж хичээлд тохирох шалгуурыг авч хэрэглэнэ гэсэн үг. Ийм учраас үнэлгээний нэгжийг нэгж хичээлээс ялгаж ойлгох нь чухал юм.

## 2.2. СУРАЛЦАХУЙН ЗОРИЛТ БА СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

### Суралцахуйн зорилт:


Суралцахуйн зорилт бол сурагчдын тухайн хичээлээр судалж эзэмших мэдлэг, чадварын илэрхийлэл болно. 6-р ангийн сургалтын хөтөлбөрт унших агуулгын 8, хэл зүй агуулгын 4, бичих агуулгын 9, ярих-сонсох агуулгын 2, нийт 23 суралцахуйн зорилт байгаа болно.

### Суралцахуйн үр дүн:

Сургалтын үр дүн нь тухайн хөтөлбөрийн төгсгөлд сурагчдын олж авах ёстой мэдлэг, ур чадварыг тодорхойлсон, тухайн мэдлэг, чадвар нь яагаад тэдэнд ашигтай болохыг ойлгоход нь туслах зорилготой.

Суралцахуйн үр дүнг тодорхойлоходоо дараах шаардлагыг хангахыг зорьсон.

1. Сургалтын хөтөлбөрийн агуулгаас хэд хэдэн суралцахуйн нэгтгэж ерөнхийлсөн. Жишээ нь “Хүүрнэсэн эхийг задлан шинжилж нэгтгэн дүгнэх” үнэлгээний нэгж нь “Сурагч уншсан хүүрнэсэн эхийг задлан шинжилж, үндсэн шинжээр нь ялган таньдаг болно.”, “Сурагч хүүрнэсэн эхийн гол санаа, сэдэв болон харилцан ярианы үүргийг тодорхойлж чаддаг болно.”, “Сурагч хүүрнэсэн эхийн чухал хэсэг, зохиогчийн илэрхийлсэн санаа, мэдрэмж, сэтгэлийн өнгө аясыг тайлбарлаж чаддаг болно” гэсэн зорилтуудыг хамарсан.
2. Суралцахуйн зорилтын үндсэн агуулгыг алдагдуулахгүй, нэмж хасахгүйгээр суралцахуйн үр дүн болгон томъёолсон бөгөөд энэ хоёрыг ижил түвшинтэй байхаар томъёолсон. Дээрх хүснэгтээс үүнийг харж болно.



3. Суралцахуйн үр дүн нь сурах үйл явцыг бус, харин ямар үр дүнд хүрэх гэж хүсэж буйгаа хоёрдмол санаагүй, шууд ойлгогдохоор тодорхойлсон байна. Жишээ нь, “Сурагч алдартай хүмүүсийн захидал, намтар, өдрийн тэмдэглэл, мэдээ, богино үлгэр, өгүүллэг зэрэг хүүрнэсэн эхийг задлан шинжилж, үндсэн шинжээр нь ялган таньдаг болно.” гэвэл задлан шинжлэхийг нь үнэлэх үү?, эсвэл ялган танихыг нь үнэлэх үү? гэсэн хоёрдмол ойлголт бий болгож байна. Энд “задлан шинжилж” гэдэг үгийг хэрэглэсэн нь эхийг задлан шинжлэх процесс буюу үйл явцыг илэрхийлж байна. Харин “Сурагч алдартай хүмүүсийн захидал, намтар, өдрийн тэмдэглэл, мэдээ, богино үлгэр, өгүүллэг зэрэг хүүрнэсэн эхийг үндсэн шинжээр нь ялган таньдаг болно.” гэвэл эдгээр эхэд өгүүлэгдэж байгаа үйл явдал нь цаг хугацааны дарааллаар өрнөдөг үндсэн шинжээр нь хүүрнэсэн эх мөн болохыг нь ялган таних үр дүн тодорхой ойлгогдож байна. Ийм учраас “ялган таньдаг болно”, “тодорхойлж чаддаг болно”, “тайлбарлаж чаддаг болно” гэх мэтээр идэвхтэй, үр дүнг харуулах үйл үгээр төгсгөж, ирээдүй цагийн нөхцөлөөр хэлбэржүүлсэн. Тус ангийн хөтөлбөрийн суралцахуйн зорилтод “ялган таних, нэрлэх, тоочих, задлан шинжлэх, тодорхойлох, тайлбарлах, нэгтгэн дүгнэх, хэрэглэх” зэрэг үйл үгийг хэрэглэсэн байна.
  4. Суралцахуйн үр дүн нь тухайн хөтөлбөрийн хүрээнд эзэмших шаардлагатай хүлээсэн мэдлэг, тусгай болон ерөнхий чадвар, үнэт зүйл, хандлагад чиглэсэн байх ёстой.
  5. Суралцахуйн үр дүн нь хэмжигдэхүйц, ажиглагдахуйц байх
- 6-11-р ангийн сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтыг нэгтгэн үр дүн болгосныг дараах хүснэгтэд нэгтгэн харуулсантай танилцаж, алийг нь нэгж хичээл бүрээр хэрэгжүүлэх, алийг нь тусгай нэг нэгж хичээлээр эзэмшүүлэхийг ойлгож аваарай.

**6-р анги**

Суралцахуйн зорилт /код/	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн	Хэрэгжих байдал
<b>Унших</b>			
6.1а, 6.1.б, 6.1в, 6.1д, 6.1г, 6.1з, 6.1.ж, 6.1.з	Эхийг задлан шнжилж, нэгтгэн дүгнэх	Сурагч алдартай хүмүүсийн захидал, намтар, өдрийн тэмдэглэл, мэдээ, богион үлгэр, өгүүллэг зэрэг хүүрнэсэн эхийг үндсэн шинжээр нь ялган таньдаг болно.	Нэгж хичээл бүрээр
<b>Бичих</b>			
6.2а, 6.2.б, 6.2в, 6.2.д, 6.2з, 6.2.ж, 6.2.з	Хүүрнэсэн эх зохиож бичих	Сурагч хүүрнэсэн эхийн үндсэн шинжид тохирсон эх зохиож чаддаг болно. /захидал, өдрийн тэмдэглэл, тохиолдсон явдал, үйл явдлын мэдээ, үлгэр, өгүүллэг/	Нэгж хичээл бүрээр
6.2г, 6.2.е	Хүүрнэсэн эхийг дэлгэрүүлэх	Сурагч өгсөн мэдээллийг баримт жишээ, өөрийн санаа, харилцан яриагаар дэлгэрүүлэн бичиж чаддаг болно.	Нэг нэгж хичээлээр

Ярих- сонсох			
6.3а, 6.3б	Харилцан ярих	Сурагч тодорхой асуудлаар бусдыг ойлгон харилцаж чаддаг болно.	Нэг нэгж хичээлээр
Хэл зүй			
6.1к, 6.1л	Хэл зүй, түүний хэрэглээ	Сурагч уншсан эхээс жинхэнэ нэр, үйл үг, орон цагийн нэрийг олж, хэрэглэсэн учрыг тайлбарлаж чаддаг болсон байна.	3 нэгж хичээлээр
6.1м		Сурагч өгүүлбэрийн цөм ба цөм бус бүтцийг ялгаж, тэдгээрийг хурааж дэлгэрүүлж чаддаг болсон байна.	Нэг нэгж хичээлээр

11-р анги

Суралцахуйн зорилт /код/	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн	Хэрэгжих байдал
Унших			
11.1а	Эхийг уншиж ойлгох	Сурагч алдартай хүмүүсийн захидал, намтар, өдрийн тэмдэглэл, мэдээ, богино үлгэр, өгүүллэг зэрэг хүүрнэсэн эхийг үндсэн шинжээр нь ялган таньдаг болно.	Нэгж хичээл бүрээр
11.1б		Сурагч зохиогчийн дүгнэлт, баримт нотолгоог үзэл бодолтойгоо харьцуулж дүгнэдэг болсон байна.	Нэгж хичээл бүрээр
11.1в, 11.1г		Сурагч зохиогчийн зорилго, уншигчийн сонирхлыг татахаар сонгосон орчин нөхцөл, цаг хугацаа, эхийн шалтгаан, үрийг тодруулж, үг хэллэг, дүрслэлийг тайлбарладаг болсон байна.	Нэгж хичээл бүрээр
Бичих			
11.1а	Эх зохиож бичих	Сурагч тодорхой асуудлыг олон талаас нь эргэцүүлэн бичдэг болсон байна. /Эргэцүүлсэн эсээ/	Нэгж хичээл бүрээр
11.1б		Сурагч үйл явдлыг асуудал дэвшүүлж хүүрнэн, бичдэг болсон байна. /Аян замын тэмдэглэл/	Нэгж хичээл бүрээр
11.1в, 11.1г		Сурагч бичихдээ эшлэл, зүүлт, ном зүй ашигладаг болсон байна. /Шинжлэх ухааны хялбаршуулсан эх/	Нэг нэгж хичээлээр
Ярих- сонсох			
11.3а	Ярих	Сурагч хэрэг явдлын талаарх үзэл бодол, сэтгэгдэл, мэдрэмжээ баримтад үндэслэн ярьдаг болсон байна.	Нэг нэгж хичээлээр
Хэл зүйн хэрэглээ			
11.4а, 11.4б, 11.4д, 11.2д,	Хэл зүй, түүний хэрэглээ	Сурагч нийлмэл өгүүлбэрийг таньж, зохион найруулдаг болсон байна.	3 нэгж хичээлээр
11.4в, 11.4г,		Сурагч толь бичгээс үг сонгон найруулгад хэрэглэдэг болсон байна.	Нэг нэгж хичээлээр

## 2.3. ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР БА ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

Үнэлгээний шалгуур нь стандартын шаардлагыг хангаж, сургалтын үр дүнд хүрсэн байдлыг харуулахын тулд цуглуулдаг нотолгоог хэлнэ. Үнэлгээний шалгуур нь хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй (Sadler, 1987). Үүнд:


1. Шалгуур (criterion). Шалгуур нь “Би юу хийх ёстой вэ?” гэдэг асуултад хариулна.
2. Гүйцэтгэлийн үзүүлэлт (Achievement Standard, Performance Standard) “Би яаж хийх ёстой вэ?” гэдэгт хариулна.

### Шалгуур (criterion)

Үнэлгээний шалгуур нь суралцахуйн ямар үр дүнд хүрснийг харуулахын тулд сурагчид юу хийх ёстойг ойлгомжтой болгохоос гадна багш нарт сурагчдын амжилт/гүйцэтгэлийн талаар дүгнэлт хийх хүчин зүйлсийг тодорхойлно. Өөрөөр хэлбэл үнэлгээний шалгуур нь сурагчдад хүрсэн үр дүн, амжилтыг харуулахын тулд юу хийх ёстойг нь тодорхой харуулдаг бол багш нарын хувьд сурагчдын гүйцэтгэлийн талаар дүгнэлт хийхдээ харгалзан үзэх хүчин зүйлүүдийг харуулдаг. Сургалтын эхэнд үнэлгээний шалгуурыг сурагчдад танилцуулах нь тэдний сурах итгэлийг нэмэгдүүлж, гүйцэтгэлийг сайжруулахад туслах үр дүнтэй арга юм. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тодорхой зааж өгөх нь сургалтын хөтөлбөрт юу чухал, үнэ цэнтэй болохыг таньж мэдэхэд, сургалтын гол үр дүнд хүчин чармайлтаа төвлөрүүлж, өөрийгөө үнэлэх, эргэцүүлэн бодох замаар өөрсдийн гүйцэтгэлийг үнэлэхэд нь тусалдаг. Үнэлгээний шалгуур нь сургалтын явцыг дэмжихэд чиглэсэн сургалтын саналд хүсэлт өгөх, түүнчлэн улирлын төгсгөлийн нэгтгэн дүгнэх арга юм.<sup>2</sup>

Үнэлгээний шалгуур нь суралцахуйн үр дүнгээс ялгаатай.

- ✓ Суралцахуйн үр дүн нь сурагчийн юу сурсан байхыг харуулдаг бол үнэлгээний шалгуур нь сурагч сурсан эсэхээ яаж мэдэх вэ гэдгийг харуулна.



- ✓ Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн яаж, юугаар тодорхойлохыг зааж өгдөг.
- ✓ Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл

Үнэлгээний шалгуур нь суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой. Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур нь суралцагчийн хүрсэн үр дүн буюу амжилтыг нотлон харуулахад чиглэнэ.

6, 11-р ангийн “Хүүрнэсэн эхийг задлан шинжлэх” нэгж буюу унших агуулгын хүрээнд сурагчдын эзэмших “Сурагч алдартай хүмүүсийн захидал, намтар, өдрийн тэмдэглэл, мэдээ, богино хэмжээтэй үлгэр, өгүүллэг зэрэг хүүрнэсэн эхийг үндсэн шинжээр нь ялган таньдаг болно.” гэсэн үр дүнд сурагчид хүрсэн эсэхийг дараах шалгуураар үнэлэхээр тодорхойлсон.

1. Уншсан эхийн агуулгыг ойлгодог.
2. Уншсан эхийн бүтэц, сэдэв, гол санааг тодорхойлдог.
3. Уншсан эхийн орон ба цагийн дүрслэлээр үйл явдлын орчныг тодорхойлдог.

<sup>2</sup> <https://ctet.royalroads.ca/writing-effective-assessment-criteria/>


4. Уншсан эх дэх жишээ, баримт, мэдээллийг нэгтгэж дүгнэдэг.

5. Зохиогчийн илэрхийлсэн мэдрэмж, сэтгэлийн өнгө аясыг нь тайлбарладаг.

Үнэлгээний шалгуур томъёолоход идэвхтэй үйл үг хэрэглэх, эдгээр нь ялангуяа суралцахуйн үр дүнг томъёолоход хэрэглэсэн үйл үгтэй тохирч байх, мөн суралцахуйн үр дүнгийн танин мэдэхүйн түвшинтэй тохирч байх, суралцахуйн үр дүнг илүү тодорхой болгох, хэрхэн яаж үнэлэхийг тусгасан байна.

### Гүйцэтгэлийн үзүүлэлт ба түвшин

Гүйцэтгэлийн үзүүлэлт бол чанарын тодорхой түвшин (амжилт эсвэл гүйцэтгэл)-ийн тухай ойлголт юм. Суралцахуйн үр дүнг үнэлэх шалгуур нь суралцахуйн үр дүнд хүрсэн үү? Юу хийж чаддаг болсон бол үр дүнд хүрсэн гэх вэ? гэсэн асуултад хариулагдах бол гүйцэтгэлийн үзүүлэлт нь “Би яаж хийх ёстой вэ?” гэдэгт хариулна.



Үнэлгээний шалгуурын гүйцэтгэлийн түвшнийг тодорхойлоход анхаарах зүйл:

- Үнэлгээний шалгуурыг ямар түвшинд хангаж байна вэ? Үнэлгээний шалгуур болон гүйцэтгэлийн танин мэдэхүйн нэг түвшинд байх нь зохистой.
- Гүйцэтгэлийн түвшин бүрд гүйцэтгэх үйл харилцан адилгүй, түвшин нь ялгаатай байж болохгүй.

6-р ангийн “Унших” үнэлгээний нэгжийн “Сурагч алдартай хүмүүсийн захидал, намтар, өдрийн тэмдэглэл, мэдээ, богино үлгэр, өгүүлэг зэрэг хүүрнэсэн эхийг үндсэн шинжээр нь ялган таньдаг болно.” гэсэн суралцахуйн үр дүнг үнэлэх 5 шалгуур, тэдгээрийн гүйцэтгэлийн түвшнийг дараах хүснэгтэд харуулав.

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I түвшин	II түвшин	III түвшин	IV түвшин
Уншсан эхийн агуулгыг ойлгодог, бүтэц, сэдэв, гол санааг тодорхойлдог.	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг олж, тус бүрд юуны тухай өгүүлснийг тодорхойлдог.	Эхийн сэдэв, гол санааг түлхүүр үгээр тодорхойлдог.	Эхийн сэдэв, гол санааг түлхүүр өгүүлбэрээр тодорхойлдог.	Эхийн бүтэц, сэдэв, агуулга, гол санааны уялдаа холбоог тодорхойлдог.
Уншсан эхийн орон ба цагийн дүрслэлээр үйл явдлын орчныг тодорхойлдог.	Эхэд үйл явдал ямар орчин /хэзээ, хаана/-д өрнөж буйг тодорхойлдог.	Эхэд өрнөсөн үйл явдлыг цаг хугацааны дарааллаар эрэмбэлэн тодорхойлдог.	Эхэд үйл явдал өрнөсөн орчны дүрслэлийг дүрийн үйлдэл, үг яриатай холбон тодорхойлдог.	Эхэд үйл явдал өрнөсөн орчны дүрслэлийг эхийн сэдэв, гол санаатай холбон тодорхойлдог.
Уншсан эхээс жишээ, баримт, мэдээллийг нэгтгэж дүгнэдэг. /Уран зохиолын бус эх/	Эхээс хэнд зориулж, хэн, хэзээ, яагаад бичсэн баримтыг олдог.	Эхэд ашигласан баримтуудыг бүлэглэж, тулгуур үг, оюуны зураглалаар харуулж дүгнэдэг.	Эхэд ашигласан жишээ, баримт эхэд ямар үүрэгтэйг тайлбарлаж дүгнэдэг.	Эхэд ашигласан жишээ баримт нь зохиогчийн илэрхийлсэн үзэл бодолтой яаж холбогдож байгааг дүгнэдэг.

Зохиогчийн илэрхийлсэн мэдрэмж, сэтгэлийн өнгө аясыг нь тайлбарладаг.	Бичигчийн мэдрэмж, сэтгэлийн өнгөө аясаа илэрхийлсэн үг хэллэгийг олж тайлбарладаг.	Бичигчийн мэдрэмж, сэтгэлийн өнгөө аясаа илэрхийлсэн зарим хэсгийг эхийн бүтэцтэй холбон тайлбарладаг.	Бичигчийн мэдрэмж, сэтгэлийн өнгөө аясаа илэрхийлсэн зарим хэсгийг дүрийн үйл хөдлөл, үг яриатай холбон тайлбарладаг.	Бичигчийн мэдрэмж, сэтгэлийн өнгөө аясаа илэрхийлсэн үг хэллэгийг эхийн сэдэв, гол санаатай холбон тайлбарладаг.
---	---	--	---	--

11-р ангийн “Хэл зүйн хэрэглээ” үнэлгээний нэгж 4-ийн “Сурагч өгсөн цогцолборын хүрээнд хэлний нэгжүүдийн утга, хэлбэржилт, найруулгын үүргийг тодорхойлон тайлбарлаж чаддаг болно.” гэсэн суралцахуйн үр дүнг үнэлэх 2 шалгуур, тэдгээрийн гүйцэтгэлийн түвшнийг дараах хүснэгтэд харуулав.

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I түвшин	II түвшин	III түвшин	IV түвшин
Нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээ, үүргийг таньж, тохирох холбоосоор нийлмэл өгүүлбэр найруулдаг.	Нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээ, үүргийг таньж, тохирох холбоосоор нийлмэл өгүүлбэр найруулдаг.	Нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээ, үүргийг таньж, тохирох холбоосоор нийлмэл өгүүлбэр найруулдаг.	Нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээ, үүргийг таньж, тохирох холбоосоор нийлмэл өгүүлбэр найруулдаг.	Нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээ, үүргийг таньж, тохирох холбоосоор нийлмэл өгүүлбэр найруулдаг.
Нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээ, үүргийг таньж, тохирох холбоосоор нийлмэл өгүүлбэр найруулдаг.	Толь бичгийн төрлийг мэддэг.	Толь бичгийн уламжлал, төрөл, тэдгээрийн үүрэг, зориулалтыг мэддэг.	Өвөрмөц ба хэвшмэл хэлцийг толь бичигт хэрхэн тусгадгийг мэдэж, хэрэглэдэг.	Хэлцийг шууд нэрлэлтээр солих эсвэл зохион найруулах эх, өгүүлбэрт шаардлагатай үгийнхээ үүрэг, утгыг тольчлон хэрэглэдэг.

## Үнэлгээний шалгуурыг жилийн, нэгжийн, ээлжит хичээлийн хувьд хэрхэн ашиглаж болох вэ?

**1. Оношлох үнэлгээ:** Сургалт эхлэхийн өмнө сурагчдын эзэмшсэн суурь мэдлэг, чадварын түвшнийг тодорхойлох хэрэгтэй болдог. Өөрөөр хэлбэл сурагчдын суралцахуйд ямар ямар бэрхшээл гарч буй бэрхшээлийг илрүүлж, тэдгээрийн шалтгааныг олоход чиглэдэг.

3.5. Оношлох үнэлгээ нь хичээлийн жилийн эхэнд эсвэл нэгж хичээл, бүлэг сэдэв эхлэхийн өмнө суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг тандах зорилгоор хийх үнэлгээ байна. Оношлох үнэлгээг ажиглалт, ярилцлага, хэлэлцүүлэг, асуулт, сорил, судалгаа гэх мэт хэлбэрээр хийнэ.

*Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/425 дугаар тушаалын хавсралт*

**2. Үр дүнгийн үнэлгээ:** Энэ үнэлгээ нь хичээлийн агуулгыг сурагчид хэр эзэмшсэнийг, тухайлбал тэдний эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд үнэлгээ өгөх зорилгоор хэрэглэгддэг.

3.8. Үр дүнгийн үнэлгээг сурлагын амжилтын үр дүнг хэмжих зорилгоор бүлэг сэдвийн төгсгөл болон хагас жил /II улирлын төгсгөл/, хичээлийн жилийн эцэс /IV улирлын төгсгөл/-т хийнэ. Анги дэвших, улсын шалгалт нь үр дүнгийн үнэлгээ байна.

3.9. Үр дүнгийн үнэлгээг аман болон бичгийн шалгалт, сорил, туршилт, судалгааны ажил, тайлан, төсөлт ажил, илтгэл, эссэ, бүтээл, биечлэн хийж гүйцэтгэх зэрэг хэлбэрээр хийнэ.

*Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/425 дугаар тушаалын хавсралт*

Жилийн эцсийн шалгалтын даалгавар боловсруулахдаа тухайн ангид сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг үнэлдэг тул энэхүү шалгуурыг бүхэлд нь ашиглаж болно.

Нэгж хичээлийн явцад сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэхдээ эдгээр шалгуурыг хэсэгчлэн ашиглаж болно. Нэгж хичээлийн дараах үнэлгээг жилийн эцсийн үр дүнгийн үнэлгээтэй харьцуулахад явцын үнэлгээ, харин ээлжит хичээлийн үнэлгээтэй харьцуулахад үр дүнгийн үнэлгээ болно. Өөрөөр хэлбэл, агуулгын нэг нэгж буюу нэгж хичээлээр 8-10 орчим цагт эзэмшсэн мэдлэг чадвараа үнэлүүлж байгаа хэрэг болно.

**3. Явцын үнэлгээ:** Энэ үнэлгээг хичээл, сургалтын явцад хэрэглэх бөгөөд сурагчийн суралцах үйл хэрхэн явагдаж байгааг талаар мэдээлэл авч, багшлах үйлд тхоируулга хийх, сурагчийн хэрэгцээнд нийцсэн хариу мэдээлэл-зөвлөгөө өгөх, багш сурагчийн хамтран хэрэгцүүлэх үйл явц болно.

3.6. Явцын үнэлгээ нь суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор хичээл, сургалтын явцад тогтмол хийх үнэлгээ байна.

3.7. Явцын үнэлгээг хичээлийн явцад суралцагчийн суралцах үйлийг дэмжихэд чиглэсэн ажиглалт, асуулт, ярилцлага, хэлэлцүүлэг, бие даах ажил, рубрик, суралцагчийн өөрийн болон бусад суралцагчийн үнэлгээ гэх мэт арга, хэлбэрээр багш хийнэ. Явцын үнэлгээг сургалтын баримт бичиг /багшийн журнал/-т стандарт бус тэмдэглэгээгээр тэмдэглэж болно.

*Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/425 дугаар тушаалын хавсралт*

Явцын үнэлгээгээр сурагчдын суралцахуйтай холбоотой олон мэдээлэл цуглуулж болох бөгөөд хариу мэдээлэл өгөх олон арга хэрэгслийг судлаачид санал болгосон байдаг. Явцын үнэлгээний үр дүнд сурач “Би юу мэддэг, юу чаддаг вэ?”, “Цаашид бие дааж, багшийн дэмжлэгтэйгээр юу сурах вэ?, илүү сайн сурахын тул яах ёстой вэ?” гэдгээ ойлгоход туслах болно.

Аливаа үнэлгээ нь багш сурагчийг, сурагч өөрийгөө, эсвэл бусдыг үнэлэхэд болон багшлах, суралцах үйл ажиллагааг сайжруулахад нэмэр болохуйц хариу мэдээлэл (feedback)-ээр хангаж байвал суралцахуйд тус болно. Ийм үнэлгээний хувьд сурагчийн сурах хэрэгцээнд багшлах үйл ажиллагааг тохируулахад үнэлгээний баримт, нотолгоонууд ашиглагдаж байгаа тохиолдолд тэр нь явцын үнэлгээ болно<sup>3</sup>.

Харин ээлжит хичээлийн тухайд явцын үнэлгээг голлон ашиглах бөгөөд шалгуурт баримжаалсан үйл ажиллагааг зохион байгуулна.

Сургалтын явцад сурагчдын даалгаврын гүйцэтгэлийг үнэлэхэд рубрикийн хүснэгтээр шинжилж, үнэлж болно. Рубрикийг багш ашиглахаас гадна сурагчдад өгч өөрийнх нь гүйцэтгэлд, эсвэл бусад сурагчийн гүйцэтгэлд үнэлгээ өгүүлж болно. Сурагчдаар үнэлгээ хийлгэх рубрикийн хуудсанд оноо өгөх шаардлагагүй.

<sup>3</sup> Black, Harrison, Lee, Marshall, William; ‘Working Inside the Black Box’, 2004



Рубрик нь сурагчийн гүйцэтгэлийн янз бүрийн түвшнийг үнэлэхэд ашигладаг багц хэрэглэгдэхүүний нэг. Рубрикийг шалгуурт баримжаалан боловсруулдаг. Шалгуур нь сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй тохирч байхаар, гүйцэтгэлийн түвшин бүр нь сурагч ойлгохоор энгийн хэлээр бичигдсэн, товч, хэмжигдэхүйц байхаар төлөвлөгдсөн байна. Рубрикийг хүснэгтээр илэрхийлдэг.

Хүснэгтийн босоо баганад гүйцэтгэлийн түвшнийг, хөндлөн мөрөнд шалгуурыг бичнэ. Гүйцэтгэлийн түвшнийг зүүнээс эхлэн баруун тийш бууруулан эрэмбэлж байрлуулсан нь нийтлэг байдаг. Жишээ нь: 3х3х3 загвар

Шалгуур	Гүйцэтгэлийн түвшин		
	Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй
Шалгуур 1			
Шалгуур 2			
Шалгуур 3			

Рубрикийг яагаад хэрэглэдэг вэ?

- Үнэлгээ хийх шалгуур, түвшин тодорхой болсон байдаг. Тухайн даалгавраас хамаарч ямар шалгуураар оношилж болохыг тодорхойлно. Ийнхүү сурагчдын мэдлэг, чадварын түвшнийг тодорхойлох үзүүлэлтийг урьдчилан тодорхойлох нь багшийн цагийг хэмнэх төдийгүй үнэлгээг бодитой болгоход тусална.
- Сурагчдад өөрийн гүйцэтгэлийг бодитой үнэлэх боломж бүрдэнэ. Гүйцэтгэлээ рубрик ашиглан түвшин, шалгуурын дагуу тэмдэглэх нь богино хугацаанд бодитой үнэлгээ хийхэд тусална.
- Гаргасан үндэслэлээ тайлбарлах боломжтой. Рубрик ашигласнаар багш, сурагчид даалгаврыг хэрхэн гүйцэтгэх, тухайн даалгаврыг гүйцэтгэснээр сурагчид ямар мэдлэг, чадвар эзэмших нь ил тод болно.
- Сурагчийн идэвх оролцоог нэмэгдүүлдэг. Үнэлгээ ил тод байх нь сурагчдад сурах хүсэл тэмүүллийг төрүүлнэ.

Рубрикийг хэрхэн боловсруулах вэ?

- Даалгаврын зорилгыг тодорхойлох (ямар мэдлэг, чадвар, үнэт зүйлийг үнэлэх гэж байна вэ?)
- Шалгуур, үзүүлэлтүүдийг тодорхойлох
- Гүйцэтгэлийг түвшинчилэх (4 байвал сайн)
- Түвшин хоорондын ялгааг сайн тодорхойлох
- Гүйцэтгэлийн түвшинд харгалзах оноог өгөх
- Рубрикийг монгол хэлний хичээлд ашиглах боломжтой бөгөөд сурагчдын унших, бичих чадварыг үнэлэхэд ашиглаж болно.

6-р ангид сурагчдын эх зохиож бичих чадварыг үнэлэх рубрикийн жишээ:

Шалгуур	Хангалтгүй I-II	Дунд зэрэг III-IV	Сайн V-VI	Маш сайн VII-VIII
<b>Бүтэц:</b> Эхлэл, гол төгсгөл хэсгийн ялгаж бичдэг.	Эхлэл, гол, төгсгөлийг ялгалагүй бичсэн	Эхлэл, гол, төгсгөлийн аль нэгийг догол мөрөөр ялгаагүй бичсэн	Эхлэл, гол, төгсгөлийг догол мөрөөр ялгасан боловч буруу ялгасан	Эхлэл, гол, төгсгөл хэсгийг догол мөрөөр зөв ялгаж бичсэн
<b>Зорилго:</b> Орон, цаг хугацааны дараалал, уялдаа холбоотой бичдэг.	Эхийн агуулга бүхэлдээ уялдаа холбоогүй	Үйл явдлыг цаг хугацааны дарааллаар бичсэн боловч ихэнх хэсгийн уялдаа холбоо сул	Үйл явдлыг цаг хугацааны дарааллаар бичсэн, зарим хэсгийн уялдаа холбоо сул	Үйл явдлыг цаг хугацааны дарааллаар өрнүүлсэн, уялдаа холбоо сайтай
<b>Эхийн утга санаа</b> ойлгомжтой, тодорхой	Санаа нь тодорхойгүй, ойлгомж муутай	Санаа нь тодорхой ч уншихад сонирхолгүй, жишээ баримт бараг ашиглаагүй	Санаа нь тодорхой, ойлгомжтой, ашигласан зарим жишээ баримт тохиороогүй.	Санаа нь тодорхой, ойлгомжтой, уншихад сонирхолтой, тохирсон жишээ баримт ашигласан.
Зохиосон эхэд сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлдэг.	Сэтгэгдэл мэдрэмжээ огт илэрхийлээгүй.	Сэтгэгдэл мэдрэмжээ ганц нэг үгээр илэрхийлсэн	Сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлж, шалтгааныг нь бичсэн	Сэтгэгдэл мэдрэмжээ маш тодорхой илэрхийлдэг
Найруулга, зөв бичих дүрэм /ЗБД/	Найруулгын болон ЗБД, цэг тэмдгийн алдаа ихтэй 6-аас дээш	Найруулгын болон ЗБД, цэг тэмдгийн алдаа 4-өөс дээш	Найруулгын болон ЗБД, цэг тэмдгийн алдаа 3 ихтэй	Найруулгын болон ЗБД, цэг тэмдгийн нэг ч алдаагүй

## Гурав. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар

### 3.1. ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВАР БОЛОВСРУУЛАХ НЬ

6 дугаар ангийн монгол хэлний хичээл нь 9, 11-р ангид нэгж хичээл тус бүрээр үр дүнгийн үнэлгээ хийх бөгөөд үнэлгээний даалгавар нь сурагчдын эзэмшсэн унших чадвар, бичих чадвар, хэлний зүйн мэдлэг, ойлголт, хэрэглээ гэсэн хүрээнд даалгавар боловсруулна. Гэхдээ тухайн нэгж хичээлийн агуулгаас хамаарч зарим нэгж хичээлийн үнэлгээний даалгавар нь энэ гурван агуулгыг бүхэлд нь хамардаг бол зарим тохиолдолд өөр байж болно. Тухайлбал: “Ярих-сонсох” нэгж хичээлийн хувьд бичих чадварыг заавал үнэлэх шаардлагагүй. Өөрөөр хэлбэл нэгж хичээлийн үнэлгээ нь тухайн нэгж хичээлийн зорилго агуулгад нийцэж байх шаардлагатай гэсэн үг.

### 3.2. а НЭГЖ ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВРЫН ЖИШЭЭ: 6-Р АНГИ

Уншиж ойлгосныг амаар болон бичгээр шалгаж болно. Асуултад хариулах, хэлний зүйн мэдлэг ойлголтыг сонгох хариулттай тест, зохион бичих чадварыг задгай хариулттай даалгаврууд байж болно. Унших чадварыг үнэлгээний “Эхийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх” нэгжийн багц шалгуураар үнэлнэ.

#### **НЭГ. УНШИХ ЧАДВАР:**

Сурагчид унших гэж юу болохыг мэддэг ч унших ур чадвараа яаж ахиулах аргаа сайн мэддэггүй. Гэтэл багш нар сурагчдын их зүйл уншихыг шаарддаг ч үр дүн төдийлэн сайн байдаггүй. Сурагчдын нас сэтгэхүй, хэрэгцээнд тохирсон эхийг сонгон уншуулах явдал чухал. Уншихдаа аль болох бага хугацаанд дэлгэрэнгүй мэдээлэл авах, уншсанаа эргэцүүлэн тунгааж ойлгодог, өөрт хэрэгтэй зүйлийг олж авахаар байх нь чухал. Үнэлгээний даалгаврын жишээг 6, 11-р ангиар жишээлж танилцуулъя.

Даалгаврын зорилго: Эхийг уншиж, задлан шинжилж, үйл явдал нь цаг хугацааны дарааллаар өрнөдөг онцлог шинжээр нь хүүрнэсэн эхийг ялган таних чадварыг нь үнэлэх

**“Хусны шид” эхийг уншаад задлан шинжилж, өгсөн даалгаврыг гүйцэтгэнэ үү.**

#### Хусны шид

Нэг өдөр Мятав малд явж байгаад Асгатын цохион дээрээс хэдэн тэмээгээ дурандаж суужээ. Тэр цохио бол хажуунаас нь хус мод шахаж ургасан, гурав дөрвөн давхар байшингийн дайтай, тэрүүхэндээ өндөр гээчийн газар байсан юм.

Хүржигнэсэн сүртэй дуу гарахаар нь Мятав эргээд харсан чинь том алаг ирвэс ард нь ирчихсэн хэдхэн алхмын цаанаас үсрэн дайрахаар завдаж байлаа.

Хаашаа ч гарах газаргүй болжээ. Ирвэс биеэ хураан архирлаа. Мятав гэнэт цохионоос үсэрч өндөр хусны оройгоос зуурахад хус саван гулзайж нумарсаар Мятавыг газардуудав. Ирвэс хойноос нь үсрэхээс айн бэрхшээсэн янзтай өндөр хадны ирмэг дээр балтайн хярж, Мятав руу хий л гөлөрч байв. Мятав “Чамайг одоо” гэж шивнэн арайхийн тогтоон барьж байгаа нумарсан хусны үзүүрийг ирвэс рүү чиглүүлэн татаж байгаад тавьчхав. Хусны үзүүр чавхдан очиж ирвэсийг шавхуурдахад огцом муухай дуугарч, амь тавьсан ирвэс өндөр хаднаас цоохор арьс шидсэн мэт газарт нэвсийн унажээ.

Ингэж Мятав халз тулгарсан араатны аюулаас ухаанаанаар мултран гарсан түүхтэй.

*Ш.Цэнд-Аюуш*

**Гүйцэтгэх даалгавар:**

1. Эхэд юуны тухай өгүүлсэн бэ? /Эхэд ямар асуудал дэвшүүлсэн бэ?/
  - А. Хүн араатан хоёрын тулааны тухай
  - Б. Хүн араатан хоёрын өрсөлдөөний тухай
  - В. Гэнэтийн аюулыг хүч чадлаараа ялан дийлсэн тухай
  - Г. Гэнэтийн аюулыг арга ухаанаар ялан дийлсэн хүний тухай
2. Эхэд үйл явдал өрнөсөн газрыг дүрсэлсэн хэсэг аль нь вэ?
  - А. Өндөр хадны ирмэг дээр
  - Б. Асгатын цохион дээр
  - В. Тэр цохио бол хажуунаас нь хус мод шахаж ургасан, гурав дөрвөн давхар байшингийн дайтай, тэрүүхэндээ өндөр газар
3. Эхэд өгүүлсэн үйл явдал ямар хугацаанд өрнөсөн бэ?
  - А. Нэг өдөр
  - Б. Нэг цаг
  - В. Нэг хором
4. Эхийг “Хусны шид” гэж яагаад нэрлэснийг батлах 3 баримтыг олно уу.
  - А. Тэр цохио бол хажуунаас нь хус мод шахаж ургасан, ... өндөр гээчийн газар байсан юм.
  - Б. .... хус саван гулзайж нумарсаар Мятавыг газардуудав.
  - В. Мятав ... арайхийн тогтоон барьж байгаа нумарсан хусны үзүүрийг ирвэс рүү чиглүүлэн татаж байгаад тавьчхав.
  - Г. Хусны үзүүр чавхдан очиж ирвэсийг шавхуурдахад ...
5. Эхийн гол санаа аль нь вэ?
  - А. Гэнэтийн аюулаас хамгаалахад хүнд хүч чадал хэрэгтэйг харуулсан.
  - Б. Гэнэтийн аюулаас хамгаалахад хүнд мэдлэг, арга ухаан хэрэгтэйг харуулсан.
  - В. Гэнэтийн аюулаас хамгаалахад хүнд анхаарал болгоомж хэрэгтэйг харуулсан.
  - Г. Гэнэтийн аюулаас хамгаалахад хүнд овсгоо самбаа хэрэгтэйг харуулсан.

6. Хэрэв Асгат цохионы хажуунаас хус биш өөр мод шахаж ургасан байсан бол Мятавт юу тохиолдох байсан бол? Нэг өгүүлбэрээр бичнэ үү.

.....  
 .....

Рубрик зохиох нэг хувилбар (3x3)

	Хангалтгүй	Дунд зэрэг 5 оноо	Хангалттай 10 оноо
1. Эхийн сэдвийг тодохойлох	А, В хариултыг сонгосон бол 0 оноо	Б хариултыг сонгож эхийн сэдвийг дутмаг ойлгосноо харуулсан бол 1 оноо	Г хариултыг сонгож эхийн сэдвийг бүрэн ойлгосноо харуулсан бол 2 оноо
2. Эхэд үйл явдал өрнөсөн газрын дүрслэлийг тодорхойлох	А хариултыг сонгосон бол 0 оноо	В хариултыг сонгож үйл явдал өрнөсөн газрыг нэрлэсэн бол 1 оноо	В хариултыг сонгож үйл явдал өрнөсөн газрын дүрслэлийг олж чаддагаа харуулсан бол 2 оноо
3. Үйл явдал болсон хугацааг олох	А, Б хариултыг сонгосон бол	-	В хариултыг сонгосон бол
4. Хусны мөчрийн уян харимхай шинжийг дүрсэлсэн хэсгийг олох	А хариултыг сонгосон бол 0 оноо	“Б, В, Г” хариултаас аль нэгийг нь сонгож, хус модны онцлогийг дутмаг мэддэгээ харуулсан бол 1 оноо	“Б, В, Г” хариултыг гурвууланг нь сонгож, хус модны онцлогийг сайн мэддэгээ харуулсан бол 2 оноо
5. Эхийн гол санааг тодорхойлох	“А” хариултыг сонгосон бол 0 оноо	“Б,Г” хариултыг сонгосон бол 1 оноо	“Б” хариултыг сонгосон бол 2 оноо
6. Эхийг нэг өгүүлбэрээр дүгнэж бичих	Мятав аюулаас өөрийгөө аварч чадна гэсэн санааг гаргасан бол 0 оноо	Мятав өндрөөс унаж бэртэх магадлалтай гэсэн санааг гаргасан бол 1 оноо	Хус мод шиг уян, харимхай биш учраас хугарсан. Мятав өндрөөс унаж гэмтэх аюултай гэсэн санааг гаргасан бол 2 оноо

## ХОЁР. БИЧИХ ЧАДВАР

6 дугаар ангийн сургалтын хөтөлбөрт хүүрнэсэн эхийг уншиж, үндсэн шинжийг нь таньж мэдэхийн зэрэгцээ захидал, намтар, өдрийн тэмдэглэл зэргийг бичихдээ үйл явдлыг цаг хугацааны дарааллаар уялдаа холбоотой хүүрнэн бичиж сурсан байх зорилт байгаа. Ийнхүү цаг хугацааны дарааллаар хүүрнэн бичиж сурах нь 6-р ангийн гол зорилт бол 7-р ангид тоочин дүрсэлж бичих, 8-р ангид учир шалтгааны тайлбарлаж бичиж, 9-р ангид эргэцүүлэн дүгнэж бичих чадвар эзэмших ёстой.

Харин үйл явдлыг хүүрнэн бичих чадварыг “Эх зохиож бичих” үнэлгээний нэгжийн “Сурагч хүүрнэсэн эхийн үндсэн шинжид тохирсон эх зохиож чаддаг болно. /захидал, өдрийн тэмдэглэл, тохиолдсон явдал, үйл явдлын мэдээ, үлгэр, өгүүллэг/ гэсэн үр дүнг хэр эзэмшсэнийг мэдэхийн тулд зохиож бичих задгай даалгавар өгнө.

Хүүрнэсэн бичлэг нь хүүхдэд тохиолдсон бодит явдлыг эсвэл хэн нэгэнд, эсвэл мал амьтанд тохиолдсоын явдлыг үзэж харснаа, эсвэл бусдаас дуулж, сонссоноо бичих хэлбэр юм. Сурагчдын зохион бичих чадварыг үнэлэхэд бичих даалгавар ба онооны рубрик чухал үүрэгтэй. Сурагчдад ямар бичлэгийг илүү сайн гэж үздэгийг тайлбарлаж, үүн дээр суурилж үнэлдэг гэдгийг тайлбарлах хэрэгтэй. Нэг бичээд сайн бичиж сурдаггүй, энэ чадварыг хөгжүүлэхийн тулд тодорхой дэс дараатай үйл явц, процесс байдгийг зааж өгөх хэрэгтэй. Сурагчид ихэнхдээ нэг суугаад л бичиж дуусгана гэсэн бодолтой байдаг. Сайн бичиж сурахын тулд бичихэд бэлтгэх, анхны ноорог гаргах, энэ ноорогтоо санал зөвлөмж авах, тэдгээрийг тусган сайжруулах зэрэг үе шат туулдгийг ойлгуулах хэрэгтэй. Бичих даалгаврын жишээг 6-р ангиар жишээлж үзүүлье.

Даалгаврын зорилго: Үйл явдлыг хүүрнэн бичиж сурсныг нь үнэлэх

Ойрын үед өөрт чинь өөрт чинь ямар ямар баяртай үйл явдал тохиолдсоныг бодно уу. Энэ явдал гэрт чинь, ангид чинь, эсвэл өөр хаана ч тохиолдсон байж болно. Энэ явдал танд яагаад баяр баясгалан авч ирснийг найздаа тодорхой бичнэ үү. Үгийн тоо 150 орчим

Та нарын зохиосон эх дараах асуултад хариулагдаж байхаар бичээрэй.

1. Эхийн бүтэц бүрэн байна уу? /эхлэл, гол, төгсгөл хэсэг/
2. Эхэд үйл явдал болсон орон, цагтай холбоотой мэдээлэл байна уу?, Үйл явдлыг цаг хугацааны дарааллаар бичсэн үү?
3. Ушихад эхийн агуулга ойлгомжтой болж чадсан уу? Сонирхолтой жишээ, баримт ашигласан уу?
4. Энэ явдал яагаад чамд баяр баярласан /мэдрэмж/ төрүүлснийг бичсэн үү?
5. Зөв бичих дүрмийн болон найруулгын алдаагаа шалгасан уу?

Эдгээрийг шалгуурыг ашиглан рубрик зохион сурагчдад танилцуулж болно. /Рубрикийн жишээг 14-20-р хуудаснаас харна уу./

Сурагчдад зохион бичих даалгавар өгөхдөө сэдэв, үндэслэл, зорилго нь тодорхой байх хэрэгтэй. Зохион бичих даалгаврын сайн, муу жишээ нь:

1. “150 үгтэй хүүрнэсэн эх зохиож бичнэ үү.” гэсэн даалгаварт ямар сэдвээр, ямар зорилгоор бичих нь тодорхойгүй байна.
2. “Миний нэг өдөр” сэдвээр 150 орчим үгтэй хүүрнэсэн эх зохиож бич”. Энэ даалгаврын хувьд сэдэв нь тодорхой боловч хэнд хандаж, юуны тулд бичих нь тодорхойгүй, өөрөөр хэлбэл зорилго нь тодорхойгүй байна.
3. “Та нар өөрт тохиолдсон, эсвэл та нар харсан үйл явдлыг эргэн санана уу. Энэ нь сайн муу, эсвэл хөгжилтэй ямар ч үйл явдал байж болно. Энэ явдлын талаар найздаа зориулж бичээрэй. Найз чинь энэ явдалд оролцоогүй, нүдээр хараагүй ч гэсэн тэнд юу болсныг яг чамтай адилхан мэдрэхээр тодорхой бичээрэй.” гэвэл эхний хоёр жишээнээс харьцангуй сайн болсон ч хэт нуруу, хүүхэд бичих зорилгоосоо хазайхад хүргэж болзошгүй байна.

### **Эх зохиох даалгаврыг хэдийд өгөх вэ?**

Сургалтын хөтөлбөрт уншиж судалсан эхийг бүтэц, агуулгыг судалсан мэдлэгээ үндэслэн эх зохиож бичдэг. Эх зохионо гэдэг нь нэг суугаад бичдэг чадвар биш гэдгийг өмнө дурдсан. Иймд нэгж хичээлийн эхний хичээл дээр “Энэ нэгж хичэлээр намтар бичиж сурна” ,”... өдрийн тэмдэглэл бичиж сурна” гэх мэтээр зорилгыг нь ойлгуулж, эхийг уншиж, задлан шинжлэх явцдаа юуг, яаж бичих талаараа эргэцүүлэн бодох, төлөвлөх, эхэд хэрэгтэй мэдээлэл, баримт нотолгоо цуглуулах, бичиж ноороглох гэх мэтээр бичих үйл ажиллагаа нь чиглүүлж явах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, сурагчдын эх зохион бичих үйл явцыг зөв удирдах шаардлагатай. Багш нар хичээлийн 40 минутад ямар нэг сэдэв өгч, эх зохион бичүүлээд, шууд хурааж авч дүгнэдэг нь нийтлэг. Үүнийг өөрчлөх хэрэгтэй.

### **ГУРАВ. ХЭЛ ЗҮЙН МЭДЛЭГ, ЧАДВАР, ХЭРЭГЛЭЭ**

Сурагчид жинхэнэ нэр, үйл үг, орон цагийн нэр, тэдгээрийн утга, бүтэц, найруулгын үүрэг, өгүүлбэрийн цөм бүтэц гэсэн хэл зүйн агуулгыг судална. Энэ мэдлэг чадварыг тестээр шалгаж болно.

Даалгаврын зорилго: Өгүүлбэрийг цөм бүтцийг тодорхойлж сурсныг үнэлэх

Нэгж хичээлийн даалгаврын жишээ:

## 1. Дараах алхмаар өгүүлбэрийг шинжилж, цөм бүтцийг ялгана уу. 6-р анги

<u>Ажиллах өгүүлбэр:</u> Нэг өдөр Мятав малд явж байгаад Асгатын цохион дээрээс хэдэн тэмээгээ дурандаж суужээ.		
Алхам 1. Нийлмэл өгүүлбэрийг энгийн өгүүлбэр болгон салгаж бичнэ үү.	1.	2.
Алхам 2. Өгүүлбэр тус бүрээс цөм бүтцийг нь ялган бичээрэй.	1.	2.
Алхам 3. Хоёр өгүүлбэрийн бүрэлдэхүүнийг тодорхойлно уу.	1.	2.

## 2. Аль нь гурван бүрэлдэхүүнт өгүүлбэр вэ? /2 хариулт сонгож болно./

- А. Ирвэс нэвсийн унажээ.
- Б. Мятав гэнэт ирвэс харжээ.
- В. Ирвэс муухай дуугарсан.
- Г. Хусны үзүүр ирвэсийг шавхуурдсан.

## 3.2.6 11-Р АНГИ

**Амны бэлгэ, ашдын ерөөлтэй цастын Монгол**

Хятадын алдарт Чилияний их нурууны баруун хормойг дэрлэсэн багаахан суурингийнхан өөрсдийгөө Цастын Монгол хэмээн нэрлэх. Гансу мужийн Сүбэй шен гэх Монголын өөртөө засах суурингийнхны хувьд “Цастын Монгол” нэрээ яруу найраг шиг эрхэмлэж, угтах, үдэх гийчдэдээ уйгагүй хэлж сануулцаана. (1)

Цастын Монголчуудтай золгосон Цагаан сарын шинийн нэгэн

Хөхнуураар хөндлөн гулд тэнэж яваа сайх нөхөр /Энэхүү тэмдэглэлийг эрээчин татагч би бээр/ Дундад улс даяар улаан дэнлүү, улалзан дүрэлзэгч луун чимэглэлдээ “шатаж ноцож” асан билгийн улирлын Цагаан сарын шинийн нэгэнд Сүбэй шенд элгэмсэг дулаахан монгол гэр бүлийн дунд тухлан цагаалж суувай. Сүмбэр уулыг бэлгэдсэн Шүмэр хэмээх идээ ширээний голд байна. Энэ айлын босгыг эл өдөр алхсан бүхэн заавал амсаж дээжлэх учиртай элгэн тараг том мөнгөн аяганд мэлтгэнэнэ. Сагс гэдэг нэртэй шармал сараалжин боорцог, хоргон боов овоолсон цар, зүйл бүрийн самрыг нүд бүхэнд нь хийж алаглуулсан олон таславчтай таваг, уур савсан банш, нунтаг ааруул эзэгий, үзэм, чавган дээр шар тос хөвүүлэн аягалах сүүтэй цай... (2)

Хоорондоо гар барин “товаришилж” золгоно. “Даага далантай, бяруу булчинтай...” гэж нэг амьсгаагаар нэгжгээд ерөөл урсгахгүй, “Амуур” гээд л болчихно. Асуулт нь хариулттайгаа адилхан болохоор бүр ч амар юм.

-Амуур?

-Амуур. (3)

Шинийн нэгний өглөө гэрийн хүмүүстэйгээ золгоно гэж хадаг яндраа зэхээд хэрэндээ бэлдсэн ч хэрэг нь гарсангүй. Зүг мөрөө ч гаргасангүй. За яах вэ, Монголын Цагаан сар өмнө бий шүү дээ гэж өөртөө зориулсан өршөөлийн хууль санаачилж суув. Тэгтэл эрхэм ахан дүүс шуугьтал хувцаслаад эхэллээ. “За хүндэт гийчин минь гарч цагаална шүү дээ” л гэж байна. /Энд ирсээр “Эрхэм”, “Хүндэт” гэдэг хоёр үг нэр минь юм шиг л сонсогддог болчихсонтой нэгэнт эвлэрчхээд байгаа/ Өглөөний зургаан цагийн үес нар битүү, өмнөх зам бүдэг бадагхан тарлантаж, өчигдрийн цас зарим газарт мөстөн гялайсан нь халти үзэгдэх төдий. Жавар тачигнасан цантай үүрээр Цагаанхүү гуайн ганц охин Мандмаад сугадуулж садангуудыг нь зорилоо.

Цагаанхүү ах эхнэр Мөнхгэрэлтэйгээ урд гарч шуурхайлан алхана. Тэдний хоёр сайхан ижий нь сэрүүн тунгалаг, үр хүүхдүүдийнхээ нүд, сэтгэлийг баясгаж суудгийг дуулсан болохоор хөгшидтэй золгож, “Хоол болтол шийр зугаа” гэдэгчлэн юу эсийг ярьж хөөрөх сөн билээ гэж хөөрүүхэн бодол хөвсөлзүүлж алхсаар хэдийнээ хүрээд ирж. Нэг сууцнаас нөгөө рүү ирэхийн зуурт эгээ л саахалт руугаа морь хөлөргөн довтолгосон хөдөөх айлчин аятай цан хүүрэг савсуулчихсан нүдний булай чинь нүд сормуусныхаа цас мөсийг ч шудралгүй тэр чигээрээ орж явчихлаа. (4)

Шенгийн төвийнхөн тохилог сайхан орон сууцанд хот газрын зиндаагаар товхийтэл амьдарцаадаг аж. Илүү дутуу эд хогшил, нүсэр хүнд тавилгуудгүй, тохь тухыг эрхэмлэсэн орчин үеийн хөнгөн шийдэл бүхий цэмцгэрхэн гэр орон угтаж байсан юм. Шалаа гэгээ гэрэлтэй шаазан хавтангаар өнгөлж, ханандаа эзэн Чингисийнхээ хөргийг эсгийн дээр хатгамалдан залсан байна. Хөхнуурт Чингисийн хөрөггүй айл байдаггүй гэнэ билээ. Зочдын өрөөний эсрэг талын хананд шил болон улаан модоор хийсэн орчин үеийн хананы цогц тавиурууд байх бөгөөд түүнд нь Хятадын их удирдагч асан Мао Цзы Дуны баримал дүр урлагийн бүтээл мэт ихэмсэг залрах нь мөн л Чингис хааны хөрөг лугаа нийтлэг. (5)

...Энэ нутагт дээжийн ёс гэх хүндэтгэлийн зан үйлийг машид чухалчлах бөгөөд идээ ундаа бүхнийг дээжилнэ. Ингэхдээ эхлээд баруун гараа чамархайн тус газраа хүргэж, дараа нь дээжилж буй идээнд нөгөө гараа дэмнэн хүргээд дахин баруун гараа өөд өргөн магнайдаа адислан бөхийхийн хамт тахимаараа нахисхийн үйлдэнэ. Айлд ороход хийж өгсөн цай, цагаалга, архи гэхчлэн бүхий л ундаа шүүсийг гэрийн эзэн болон тэнд байгаа настнуудаар дээжлүүлж байж айлчин сая аяганы амсар зууна. Гэрийн эзэгтэй цай хийж барихад цайгаа барьсаар настан дээр очиж “Настанд цайгаа дээжлүүлье ээ” гэнэ. Хөгшид дээжлэх зан үйлийг нарийн дэс дарааллын дагуу хийж цайг уруулдаа хүргэн буцааж өгөхөд л зочин цайгаа өөрийн өмнө тавин уух эрхтэй болно. (6)

... Өвлийн нарны туниа муутай илч цонхны шил шүргэн хөлөргөх үес бид гэртээ буцаж ирэхэд айл хөршийн сайн нөхөд нь манай хоёртой яаруу сандруу золгочоод эргэж тухтай айлчлах юм болоод гарлаа. Улаанбаатарынхан айл хөршийнхөө улстай анд нөхөд бололцон сүжрээд байдаггүй, амьдран суугаа орчин нөхцөл нь ч тийм боломжоор хомсхон. Харин энд сайхан монгол ёсоор айл аймаг, амьтан ах дүүтэйгээ ойр салгуу амьдардаг нь тун чиг дотно санагдаж билээ. Түүгээр ч барахгүй Өвөр Монголын тийм хүн, Шинжааны ийм хүн, Хөхнуурын тэр найз Гансувд маань айлчлаад гэж ирээд л Цастын Монголд буусан суусан бүхнийг халуун сэтгэлээр дурсаж, хаа холын Монгол улсынхаа буян заяаг тэнгэрт даатган цай сүүгээ дээжлэн, Өвөр Монголд үзэгдээд өнгөрдөг Монголын уран бүтээлчдийг “Одон” телевизээр харснаа бахдаж, өөг нь хүртэл гоо болгон ярих ажээ. (7)

Цаст уулын хормой дахь цайлган монголчууд энд дөрөвхөн мянгуулаа атлаа дөрвөн зууны түүхийг ажралгүй үүрээд иржээ. (8)

### Гүйцэтгэх даалгавар:

Мэдлэг, ойлголтыг илрүүлэх даалгавар:

1. “Цастын Монгол” гэж нэрлэсэн суурингийнхан аль улсын нутаг дэвсгэрт байдаг вэ? /1 оноо/
  - А. Өвөрмонголын өөртөө засах орны нутагт
  - Б. Хятад улсын нутаг дэвсгэрт
  - В. Монголын өмнөд хэсгийн нутаг дэвсгэрт
  - Г. Өвөрмонголын хойд нутагт
2. Зохиогчийн хувьд ямар хоёр үг нэр нь юм шиг л санагддаг болчихсон бэ? /1 оноо/
  - А. Найз, нөхөр
  - Б. Эрхэм, дотно
  - В. Эрхэм, хүндэт
  - Г. Хүндэт найз минь



3. Цогцолбор бүрийн утгыг эргэцүүлээд, утгын уялдаа холбоо, дарааллаар нь зөв харгалзуулаарай. /8 оноо, зөв харгалзуулсан бол тус бүр 1 оноо/

Цогцолборын утга санаа	Цогцолборын дугаар
А. Түүх, соёл, ёс заншлаа марталгүй тээж ирсэн монголчуудын өгүүлсэн.	1
Б. Айл аймаг, ах дүүтэйгээ амь нэгтэй амьдардаг монгол ёсны тухай өгүүлсэн.	2
В. Цагаан сарын хүндэтгэлийн ширээг дүрсэлсэн.	3
Г. Гэртээ золголгүй, ахмад настандаа эхлэн золгож, цагаалдаг тухай өгүүлсэн.	4
Д. Цагаан сарын мэндийн үгийн ялгааг өгүүлсэн.	5
Е. Дээжийн ёс гэх хүндэтгэлийн зан үйлийн тухай өгүүлсэн.	6
Ё. Цастын Монгол нэрээ эрхэмлэх суурингийнхны тухай өгүүлсэн.	7
Ж.Цастын монголчуудын гэрийн дотоод байдлын тухай өгүүлсэн.	8

**Эхийг задлан шинжлэх чадварыг илрүүлэх даалгавар**

4. Эхийн 2, 4, 6, 8 дугаар цогцолбороос нэг нэг түлхүүр өгүүлбэрийг олж бичнэ үү. /4 оноо, цогцолбор тус бүр 1 оноо/

2 дугаар цогцолбор .....

4 дүгээр цогцолбор .....

6 дугаар цогцолбор .....

8 дугаар цогцолбор .....

5. Зохиогчийн уншигчдад хэлэх гэсэн санаа нь аль догол мөрд илэрч байна вэ? /2 оноо/

А. 8                      Б. 7                      В. 1                      Г. 3

6. Аян замын тэмдэглэлийн сэдвийг зөв тодорхойлсон хэсгийг олоорой. /2 оноо/

А. Хятад болон монгол ёс заншлын тухай

Б. Цагаан сар тэмдэглэж ирсэн монгол ёс заншлын тухай

В. Ёс заншлаа хадгалж үлдсэн монгол үндэстний тухай

Г. Өвөр монголчуудын халуун сайхан сэтгэлийн тухай

7. “Цаст уулын хормой дахь цайлган монголчууд энд дөрөвхөн мянгуулаа атлаа дөрвөн зууны түүхийг ажралгүй үүрээд иржээ” гэж дүгнэжээ. Зохиогч юуг үндэслэж ийнхүү дүгнэсэн бэ? Үүнийг батлах гурваас доошгүй жишээ баримтыг олж бичнэ үү. /6 оноо/

- .....
- .....
- .....
- .....
- .....
- .....



б. Зүг мөрөө ч гаргасангүй. За яах вэ, Монголын цагаан сар өмнө бий шүү дээ гэж өөртөө зориулсан өршөөлийн хууль санаачилж суув.

.....  
 .....  
 .....

### Унших чадварыг үнэлэх даалгаврын зөв хариулт, тайлбар

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1.1а. Аян замын тэмдэглэл эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог тайлбарлаж, сэдэв, гол санааг тодорхойлох” гэсэн суралцахуйн зорилт буюу чадварыг илрүүлнэ	Сурагч уран зохиолын бус эхийн сэдэв, гол санааг тодорхойлж, агуулгын уялдаа холбоог тайлбарладаг болсон байна.

Энэхүү сорилын 10 даалгаврын эхний гурав нь сурагчдын эхийг уншаад хэр зэрэг ойлгосныг илрүүлэх зорилготой даалгавар болно.

1 дүгээр даалгаврын зөв хариулт: **Б.Хятад улсын нутаг дэвсгэрт**

2 дугаар даалгаврын зөв хариулт: **В. Эрхэм, хүндэт**

3 дугаар даалгаврын зөв хариулт: **А8, Б7, В2, Г4, Д3, Е6, Ё1, Ж5.** Энэхүү даалгавар нь эхийн агуулгын уялдаа холбоог ойлгосныг илрүүлэх зорилготой. Өөрөөр хэлбэл цогцолбор бүрийн утгыг ойлгохтой холбоотой юм.

#### Эхийг задлан шинжлэх чадварыг илрүүлэх даалгавар

4 дүгээр даалгаврын зөв хариулт: Дараах өгүүлбэрийг олж бичсэн бол 4 оноо өгнө. /Тус бүр 1 оноо/

2 дугаар цогцолбор: Дундад улс даяар улаан дэнлүү, улалзан дүрэлзэгч луун чимэглэлдээ “шатаж ноцож” асан билгийн улирлын цагаан сарын шинийн нэгэнд Сүбэй шенд элгэмсэг дулаахан монгол гэр бүлийн дунд тухлан цагаалж суувай.

4 дүгээр цогцолбор: “За хүндэт гийчин минь гарч цагаална шүү дээ” л гэж байна.

6 дугаар цогцолбор: Хөгшид дээжлэх зан үйлийг нарийн дэс дарааллын дагуу хийж цайг уруулдаа хүргэн буцааж өгөхөд л зочин цайгаа өөрийн өмнө тавин уух эрхтэй болно.

8 дугаар цогцолбор Цаст уулын хормой дахь цайлган монголчууд энд дөрөвхөн мянгуулаа атлаа дөрвөн зууны түүхийг ажралгүй үүрээд иржээ.

Энэхүү даалгавар нь цогцолбороос түлхүүр өгүүлбэрийг олох чадварыг илрүүлэх зорилготой.

5 дугаар даалгаврын зөв хариулт: **А8.** Энэ даалгавар нь эхээс зохиогчийн санааг олж тодорхойлох чадварыг илрүүлэх зорилготой. Зохиогчийн санааг олж, тодорхойлсны дараа 8 цогцолбороос аль цогцолборт ямар үг, өгүүлбэрээр илэрч байгааг тунгаан бодох учраас чадварыг илрүүлэх даалгавар гэж үзнэ. Сурагчид ээлжит хичээлийн явцад зохиогчийн гол санааг олохын тулд цогцолбор бүрд илрэх санааг ойлгож унших, тунгаан бодож сурсан байх учиртай. Тиймээс энэхүү даалгаврыг гүйцэтгэхдээ цогцолбор бүрийн утгыг тодорхойлсны дараа хамгийн чухал буюу зохиогчийн хувьд уншигчдад хэлэх гэсэн санааг олох учиртай юм. Хэрэв сурагч цогцолбор бүрийн утгын ялгааг гаргах, цогцолборуудаас хамгийн чухал гол санааг олж унших арга барилд суралцаагүй бол зөв хариултыг олох боломжгүй юм. 8 дугаар цогцолбороос бусад цогцолборт зохиогчоос уншигчдад хэлэх гэсэн санаа илрээгүй, харин гол санааг дэмжих утгууд илэрнэ.

6 дугаар даалгаврын зөв хариулт: **В. Ёс заншлаа гээгээгүй монгол үндэстний тухай.**

Энэ даалгавар нь уншсан эхийг сэдвийг тодорхойлох чадварыг илрүүлэх зорилготой. Сурагчид уншсан зохиолд ямар асуудал дэвшүүлснийг бодож, тунгаан унших арга барилтай болсон байх учиртай. Үүний тулд цогцолбор бүрд юу өгүүлснийг тодорхойлсны үндсэн дээр эхэд зохиогчийн дэвшүүлсэн асуудал буюу сэдвийг тодорхойлж чадах юм.

<i>Суралцахуйн зорилт</i>	<i>Суралцахуйн үр дүн</i>
11.1б. Зохиогчийн дүгнэлт, баталгаа нотолгоог үзэл бодолтойгоо харьцуулж дүгнэх	Сурагч зохиогчийн дүгнэлт, баримт нотолгоог үзэл бодолтойгоо харьцуулж дүгнэдэг болсон байна.

7 дугаар даалгаврын зөв хариулт: /6 оноо, баримт нотолгоо тус бүр 1 оноо/

Энэ даалгавар нь зохиогчийн ашигласан баталгаа нотолгоог “Цаст уулын хормой дахь цайлган монголчууд энд дөрөвхөн мянгуулаа атлаа дөрвөн зууны түүхийг ажралгүй үүрээд иржээ.” гэсэн дүгнэлттэй нь холбон ойлгох чадварыг илрүүлэх зорилготой.

- 1 дүгээр цогцолборт: Цастын Монгол” нэрээ яруу найраг шиг эрхэмлэж, угтах, үдэх гийчдэдээ уйгагүй хэлж сануулцаана.
- 2 дугаар цогцолборт: Цагаан сарын ширээн дэх идээ зоогийг тоочсон байдал
- 3 дугаар цогцолборт: Цагаан сарын “Амуур” мэндчилгээний үг
- 5 дугаар цогцолборт: Чингисийнхээ хөргийг эсгийн дээр хатгамалдан залсан байдаг.

8 дугаар даалгаврын зөв хариулт: **В.1б, 2г, 3а, 4в** /2 оноо/ Энэ даалгавар нь эхээд зохиогчийн ашигласан нотолгоо, дүгнэлт, сэтгэгдэл, үзэл бодлоо илэрхийлсэн хэсгийг таньж олох чадварыг илрүүлэх зорилготой.

9 дүгээр даалгаврын зөв хариулт: /6 оноо/. Энэ даалгавар нь зохиогчийн дүгнэлт, баталгаа нотолгоог өөрийн үзэл бодолтой харьцуулан дүгнэх чадварыг илрүүлэх зорилготой. Цастын монголчуудыг өнөөгийн бидэнтэй харьцуулж үзэл бодлоо илэрхийлсэн бол 3 оноо, өөрийн үзэл бодлыг зохиогчийнхтой харьцуулан дүгнэсэн бол 6 оноо өгнө./

<i>Суралцахуйн зорилт</i>	<i>Суралцахуйн үр дүн</i>
11.1в. Уран дүрслэл, мэргэжлийн үг хэллэгийг хэрэглэсэн зорилгыг тодруулж, утга, үүргийг тайлбарлах	Сурагч зохиогчийн зорилго, уншигчийн сонирхлыг татахаар сонгосон орчин нөхцөл, цаг хугацаа, эхийн шалтгаан, үрийг тодруулж, үг хэллэг, дүрслэлийг тайлбарладаг болсон байна.
11.1г. Орон, цаг, зорилго, шалтгааны утгыг эхийн жишээгээр харьцуулан, тайлбарлах	

10 дугаар даалгаврын зөв хариулт: /4 оноо, асуулт тус бүр 2 оноо/. Энэ даалгавар нь зохиогчийн сонгосон үг хэллэг эхэд ямар үүрэгтэйг ойлгосноо харуулах зорилготой.

## Дөрөв. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал

Хичээлийн жилийн эхэнд түвшин тогтоох гарааны үнэлгээг хийдэг уламжлалтай. Ихэнх тохиолдолд сурагчдын хэдэн хувь А, хэдэн хувь В, хэдэн хувь С, хэдэн хувь D, хэдэн хувь F үнэлгээтэй шалгагдсаныг мэдээлдэг. Харин шалгалтын үр дүнд шинжилгээ хийж, аль даалгаврын гүйцэтгэл хамгийн өндөр, аль хамгийн бага үзүүлэлтэй байсан, ямар агуулгыг сурагчид бүрэн дүүрэн эзэмшсэн, ямар агуулгыг дутуу хагас, ямыг нь буруу зөрүү ойлгосныг илрүүлж түүнийг засаж сайжруулах ажил хийгдэх учиртай.

Үр дүнгийн үнэлгээний үр дүнд үндэслэн нэг ангид сурагчид мэдлэг, чадварын түвшнээр хэд хэдэн бүлэг болгож, тус бүрээр ялгаатай даалгавар өгч ажиллуулах замаар хүүхэд бүрийн түвшнийг нь ахиулах зорилго тавьж ажиллах хэрэгтэй.

“Ялгавартай заах арга гэдэг нь хүүхдийн сонирхол хэрэгцээ, суралцах мотив зэрэгт нь тохируулан өөр өөр байх сургалтын арга юм. Маш тодрхой чиглэсэн хичээлийн зорилт, бүлэг бүрдүүлэх, урьдчилсан үнэлгээ буюу хариу арга хэмжээ, уян хатан бүлэг бүрдүүлэх, сургалтын явцад хүүхдийн сонгох боломж олгох, явцын үнэлгээ зэрэг ялгавартай сургалтын аргыг зарим багш тухайн хичээлийн агуулга, хүүхдийн хэрэгцээтэй уялдуулан заадаг сайн арга гэж үздэг. Ялгаатай хандах сургалт нь сурахад бэрхшээлтэй болон зохих түвшинд, үүнээс өндөр түвшинд сурч байгаа сурагчдад тэдний түвшинд тохирсон асуудлыг шийдвэрлэх боломжийг олгодог.

Сурагчдын даалгаврын гүйцэтгэлд шинжилгээ хийх жишээг дараах жишээгээр үзүүлж байна.

**Аль нь гурван бүрэлдэхүүнт өгүүлбэр вэ?**

**/2 хариулт сонгож болно./**

- А. Ирвэс нэвсийн унажээ. /0 оноо/
- Б. Мятав гэнэт ирвэс харжээ. /2 оноо/
- В. Ирвэс муухай дуугарсан. /0 оноо/
- Г. Хусны үзүүр ирвэсийг шавхуурдсан. /1 оноо/

Сурагчдын энэ даалгаврыг гүйцэтгэсэн хариултад шинжилгээ хийж үзье. Даалгаврын гүйцэтгэлээс харахад сурагчдын хэдэн хувь А, хэд нь Б, хэд нь В хариултыг сонгосныг анхаарч, яагаад эдгээр хариултыг сонгосны шалтгааныг багш таамаглах шаардлагатай.

- **“А, В” хариулт сонгосон сурагч:** Зарим сурагч тус даалгаврын өгөгдөлд “гурван бүрэлдэхүүнт өгүүлбэр” гэснийг анхаарч, өнгөц хандсанаас учраас энэ хариултыг сонгосон байх магадлалтай. Энэ нь хоёр ба гурван бүрэлдэхүүнт өгүүлбэрийг ялгаж чаддаггүй, энэ талаар огт ойлголтгүй харуулж байна. Ихэвчлэн үгийн тоог анхаарч сонгосон гэсэн үг.
- **“Г” хариулт сонгосон сурагч:** Энэ хариултыг сонгосон сурагчид шууд тусагдахуун нь өгүүлбэрийн гол гишүүдийн нэг гэдгийг мэддэг. Мөн гурван бүрэлдэхүүнт цөм өгүүлбэрийн өгүүлэхүүн нь заахын тийн ялгалтай үгийг захирдаг гэдгийг мэддэг гэсэн үг. Энэ хариултыг сонгосон сурагч зөв хариулсан байна. Гэхдээ заахын тийн ялгалын нөхцөл тэг хэлбэрээр илэрдгийг мэддэггүй учир “Б” хариултыг сонгоогүй байна.
- **“Б” хариулт сонгосон сурагч:** Энэ хариултыг сонгосон сурагчид “Б” хариулт сонгосон сурагчдыг бодвол заахын тийн ялгалын нөхцөл тэг хэлбэрээр илэрдэг болохыг мэддэг нь харагдаж байна.

11-р ангийн даалгаварт шинжилгээ хийх жишээ:

6 дугаар даалгавар: **Аян замын тэмдэглэлийн сэдвийг зөв тодорхойлсон хэсгийг олоорой. /2 оноо/**

- А. Хятад болон монгол ёс заншлын тухай
- Б. Цагаан сар тэмдэглэж ирсэн ёс заншлын тухай
- В. Ёс заншлаа хадгалж үлдсэн монгол үндэстний тухай
- Г. Өвөр монголчуудын халуун сайхан сэтгэлийн тухай

Сурагчдын энэ даалгаврыг гүйцэтгэсэн байдалд шинжилгээ шинжилгээ хийж үзье.

- **“А” хариулт сонгосон сурагч** хувилбарт монгол ёс заншлаас гадна Хятадын гэж онцолсон хариултыг сонгосон нь эхийг анхаарч уншаагүйтэй холбоотой гарсан алдаа болно.
- **“Б, Г” хариулт сонгосон сурагч:** Энэ хоёр хариултыг сонгосон сурагчид аян замын тэмдэглэлийн 2, 4 дүгээр цогцолборт илэрсэн санааг эхийн сэдэвтэй андуурч сонгосонтой холбоотой алдаа гарсан байна.
- **“Б” хариулт сонгосон сурагч:** Зохиогч Хятадын өргөн уудам нутгийн нэгээхэн хэсэгт цөөхүүлээ үлдсэн хэдий ч монгол уламжлалт ёс заншлаа, цагаан сар тэмдэглэх ёс жаягаа гээгээгүй төгсгөлийн цогцолборт дүгнэсэн аж. Тиймээс зөв хариулт нь “ёс заншлаа гээгээгүй монгол үндэстний тухай” гэсэн хариулт болно.

Сурагчдын үнэлгээний үр дүнгийн нэгтгэлийн хүснэгтийг экселийн файл үүсгэн хийх бөгөөд сурагч тус бүрийн гүйцэтгэлийн оноог шивэхэд үр дүн нь шууд нэгтгэгдэж байхаар томьёо оруулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, сурагчдын оноог шивээд дуусахад даалгавар тус бүрээр хэдэн сурагч бүрэн гүйцэтгэсэн, хэд нь дутуу гүйцэтгэсэн, хэд нь огт чадаагүй зэрэг дүн шууд бодогдсон байна. Энэ нь тухайн ангийн сурагчид хэлний зүйн мэдлэг ойлголт болон унших ба бичих чадвар, ямар түвшинд байгааг харуулах төдийгүй бататгал хичээлийн сэдэв сонгох, төлөвлөлт хийх суурь үндэс болно. Жишээ нь:

Нэгж хичээлийн үнэлгээний баримтыг нэгтгэх

	Унших даалгавар 10 оноо					Бичих						Хэл зүй		Нийт оноо
	1. Эхийн сэдвийг тодохойлох	2. Эхэд үйл явдал өрнөсөн газрын дүрслэлийг тодорхойлох	3. Хусны мөчрийн уян харимхай шинжийг дүрсэлсэн хэсгийг олох	4. Эхийн гол санааг тодорхойлох	5. Эхийг нэг өгүүлбэрээр дүгнэх	1. Эхийн бүтэц /1 оноо/	2. Цаг хугацааны дараалал /2 оноо/	3. Үйл явдлын үялдаа холбоо /2 оноо/	4. Ашигласан жишээ баримт /2 оноо/	5. Мэтрэмж сэтгэгдэл /1 оноо/	6. ЗБД, найруулгын алдаа /2 оноо/	Өгүүлбэрээс цөм бүтцийг ялгах /3 оноо/	3 бүрэлдэхүүн өгүүлбэрийг сонгох /2 оноо/	
Сурагч 1														
Сурагч 2														

**ЕБС-ийн Монгол хэл хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж боловсруулсан ажлын хэсэг:**

Ш.Оюунцэцэг                      БМДИ-ийн зөвлөх багш

**Хөндлөнгийн шинжээч:**

Ө.Цэндсүрэн                      Монгол улсын гавьяат багш

**Техникийн редактор:**

Т.Отгон-Эрдэнэ                      Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн  
Ш.Сувдмаа                              Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

**Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:**

С.Мөнхмаа                              Интерпресс ХХК-ийн дизайнер, магистр

**Цаасны хэмжээ:**                      А4

**Хэвлэлийн хуудас:**                      4.7 х.х





*Дэлгэрэнгүй мэдээллийг:*

[www.eec.mn](http://www.eec.mn)



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,  
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,  
Утас/Факс: 976-11 7011- 8486  
И-мэйл: [info@eec.mn](mailto:info@eec.mn) Вэб: [www.eec.mn](http://www.eec.mn)